



ЗОРИЛГО

Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх



Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“Иргэдийн Дуу Хоолой Ба Түүний Үр Нөлөө” аргачлал Тойм




Citizen Voice and Action

“Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлал нь иргэдийн өдөр тутмын амьдралд хамгийн их нөлөө үзүүлдэг төрийн үйлчилгээг сайжруулахын тулд иргэд болон төр хоорондоо **харилцан ярилцах замаар нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх** аргачлал юм.



Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө аргачлалын мөчлөг



Нэгдүгээр үе шат: Бэлтгэл үе шат



Иргэд оноо өгөх дасгал



- “Оноо өгөх” дасгал нь төрийн үйлчилгээг үзүүлэгч, хүртэгч аль алинд нь үйлчилгээний чанарын гүйцэтгэлийг энгийн аргаар үнэлэх бодомжийг олгоно.
- Иргэд 5 янзын инээмсэглэлээр үйлчилгээний чанарт үнэлээ өгнө.




Хоёр дугаар үе шат – Иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах



Иргэдийн дунд уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах нь шатанд иргэдийн өдөр тутмын амьдралд хамгийн их нөлөө үзүүлдэг төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэдээр үнэлүүлж, тэдний саналыг сонсох уулзалт байна.



Оноо өгөх дасгал ажлын жишээ



ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Тус аргачлалыг хэрэгжүүлэх хугацаа урт, жил дамнан хэрэгждэг учир ажлын хэсгийн гишүүд өөрийн үндсэн ажлын хажуугаар аргачлалыг хэрэгжүүлэхэд бэрхшээл гардаг. Иргэдтэй уулзах уулзалтад иргэдийг цуглуулах ажил бэрхшээлтэй байдаг. Зарим үед 5-6 хүнтэй уулзаж, санал авах үе байдаг. Тууштай ажиллах хэрэгтэй тэгж байж үр дүн гарна.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

2018 онд хэрэгжүүлсэн “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлалын хэлэлцүүлэгт оролцсон сэтгэгдэл өндөр байна. Авч буй санал нь ойлгомжтой, хялбар байсан. Цаашид бусад хэлэлцүүлэгт энэ аргыг ашиглавал үр дүнтэй санагдсан. Иргэдийн оролцооны судалгааны үр дүнг харьцуулахад иргэдийн оролцоо бүхий хяналт хэрхэн бий болгох, тодорхой ажил хийдэггүй, шийдвэр гаргах түвшинд оролцох боломжгүй байдаг байсан. Энэ арга хэрэгжсэнээр иргэд ИТХ-ын талаар мэдлэгтэй, төр иргэний харилцаа сайжирсан, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо нэмэгдсэн. **Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 9-р багийн иргэн М.Бямбасүрэн**

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, үйлчилгээ авсан иргэд сэтгэл хангалуун байх болсон.

Аймгийн ИХТ нь иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө аргачлалыг хэрэгжүүлж, цаашид үйл ажиллагааг өргөжүүлэх туршлагатай болсон.

Иргэд төлөөллийн байгууллага болон төрийн үйлчилгээний талаар мэдээлэлтэй болж, үйл ажиллагаа чиг үүргийн хүрээнд хийж буй ажилд өөрийн санал хүсэлтэй өгөх болсон.

Хавсралт 1. Ажлын хэсэг байгуулах тухай 03 дугаар тогтоол



Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрөөс үзүүлж буй үйлчилгээ иргэдэд тэгш чанар хүртээмжтэй хүрч байгаа эсэхийг иргэдээр тодорхойлуулж, түүнийг сайжруулах боломжийг тодорхойлох зорилгоор Бүсийн оношлогоо эмчилгээний төв дээр "Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө" аргачлалыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганбат- ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч

Гишүүд: Б.Норовсүрэн - Насан туршийн боловсролын төвийн дарга

Б.Сайнжаргал- Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга

Г.Түвшинбаяр- БОЭТ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн

Т.Нарангараа- аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Б.Туяацэцэг- аймгийн ИТХ-ын ажилтан

М.Мөнхсүрэн - аймгийн ИТХ-ын ажилтан

Б. Шүрэнцэцэг- Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын
Улсын байцаагч

Б.Отгонжаргал - Хүний эрхийн үндэсний комиссын

Өвөрхангай аймаг дахь мэргэжилтэн

Г.Лхамсүрэн - МШУТ –ийн ажилтан

Б.Эрдэнэзул - МШУТ –ийн ажилтан

Б.Ууганхүү - ДЗМОУБ-ын ажилтан

Б.Одгэрэл - ДЗМОУБ-ын ажилтан

Т.Пүрэвдулам - ДЗМОУБ-ын ажилтан

Б.Пүрэв-Өлзий - ДЗМОУБ-ын ажилтан

Г.Гантөмөр - Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

Г.Мөнх-Эрдэнэ - БСУГ-ын мэргэжилтэн

Б.Төмөртогтох – Арвайхээр сумын ЗДТГ-ын Нийгмийн бодлогын
асуудал хариуцсан түшмэл

Д. Анхбаяр- Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг боловсруулан, батлуулан, хэрэгжүүлж, үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Б.Ганбат /-д үүрэг болгосугай.

ДАРГА



А. ИШДОРЖ

2. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ИРГЭДИЙН ХЯНАЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Ц.БЯМБАДОРЖ, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга. Соёлын арга зүйч, төрийн захиргаа удирдлага, нутгийн удирдлагын менежер, хууль зүйн ухааны магистраар мэргэшсэн. 2004 оноос Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ажиллаж эхэлсэн. 16 дахь жилдээ ажиллаж байна.

Холбоо барих утас: 89130497

Цахим хаяг: Byambaa_ith@yahoo.com

АГУУЛГА

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын “ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт төсөл”-ийн хүрээнд “Мэдээллийн хөтөч баг”, “Иргэний хяналтын зөвлөл” байгуулан ажиллаж байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

2012 оноос хойш орон нутагт хэрэгжиж байгаа иргэдийн оролцоотойгоор орон нутгийн нэн тэргүүний тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхээр орон нутагт эрхийг олгож жил бүр жил бүр /ОНХС-аас дунджаар 70.0-160.0 орчим сая төгрөгийн/ хуваарилж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил асуудалд иргэдийн санал, санаачилга хэрхэн тусгагдсан, төсвийн төлөвлөлт, зохион байгуулалт, зарцуулалт, гүйцэтгэлийг хууль журмын хүрээнд хэрхэн зохион байгуулж үйл ажиллагаанд иргэдийн болон төлөөллийн байгууллагын хяналт, үнэлгээ /иргэдийн аудит хийгдэх/ хийх ажил хийгддэггүй, иргэдийн оролцоог хангахгүй байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын дэмжлэгт төсвийн талаар иргэдийг хууль эрх зүйн болон үйл ажиллагааны талаар төрийн байгууллагаас иргэдэд мэдээлэл өгөх, мэдээлэл солилцох ажил хийгдэхгүй, орон нутгийн төрийн албан хаагчид буюу сумын удирдлага, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, санхүүгийн мэргэжилтнүүд, багуудын Засаг дарга нарын түвшинд асуудлыг зонхилон шийдвэрлэдэг нь ОНХС-нд иргэдийн оролцоог хангах тулгамдсан асуудал болсон гэж үзсэн.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

ОНХС-ийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдалд хяналт тавих орон нутгийн иргэдийг хамруулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 05 дугаар сараас 2019 оны 12 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын дэмжлэгийн талаар иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, төрийн байгууллага, иргэдийн мэдээллийн эргэх холбоог сайжруулах “Мэдээллийн хөтөч”-ийн багийг бэлтгэх, ОНХС-ийн төсвийн хэрэгжилтийн үе шат бүрд нь хяналт, үнэлгээ хийх “Иргэний хяналтын сайн дурын зөвлөл” буюу Иргэний аудитын баг сум, багийн түвшинд байгуулах, иргэдийг чадавхжуулах ажлыг холбогдох



сургалтын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх, мөрдүүлэх ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх журам, аргачлалыг боловсруулж, НӨУБ-аас батлан хэрэгжүүлсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

ОНХС-ийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах талаар: /ОНХС-ийн Мэдээллийн хөтөч баг” ажиллуулах/

- ОНХС-ийн үйл ажиллагааг нь мэдээлж байх чиг үүрэг бүхий иргэдийн оролцооны “Мэдээллийн хөтөч баг”-ийг багуудад тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй, нийт 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллах журмыг нь боловсруулан багийн ИНХ-ын хуралдаанаар нь хэлэлцүүлж батлуулсан.
- Төмөрбулаг суманд ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2019 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, их засварын жагсаалтын танилцуулгын судалгааг гаргаж, гарын авлага болгон хэвлүүлж, 500 гаруй өрхөд хүргэж, 5 багийн төвд байрлуулсан мэдээллийн самбарт ил тод тавьж, стенд хэвлэлээр хийлгэсэн зөөврийн самбараар болон багуудын ИНХ-аар мэдээлж, хөлтэй самбарыг Иргэний танхимд ил тод байрлуулан иргэдэд танилцуулж, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын мэдээллийг ИТХ-ын цахим хуудсанд байршуулсан. 5 багийн ИНХ-ын хуралдаанд оролцсон 250 гаруй иргэдэд болон 3 багт зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцогч 150 иргэдэд, давхардсан тоогоор 500 хүнд ил тод мэдээлж хүргэсэн.
- ОНХС-ийн 2013-2019 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын зурагжуулсан танилцуулга хийж иргэдэд мэдээлсэн.
- “Төмөр сумын Орон нутгийн хөгжлийн сан” цахим хуудсыг шинээр нээж, ОНХС-ийн мэдээллийг цахим хуудсаар хүргэх, хүлээж авах боломжийг бүрдүүлсэн.

ОНХС-ийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангах талаар: /“Иргэний хяналтын зөвлөл” байгуулж ажиллуулах/:

- ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, чиг үүрэг бүхий иргэдийн оролцооны ОНХС-ийн “Иргэний хяналтын зөвлөл”, багуудад тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр, нийт 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллах журмыг нь боловсруулан, багийн ИНХ-ын хуралдаанаар нь хэлэлцүүлж батлуулсан.
- ОНХС-ийн “Иргэний хяналтын зөвлөл”, Мэдээллийн хөтөч” баг-ийн 40 гишүүдэд Иргэний оролцооны идэвхжүүлэгч бэлтгэх 14 цагийн академик сургалт явуулж, сертификат олгож, гарын авлагаар хангасан.
- ОНХС-ийн “Иргэний хяналтын зөвлөл”, Мэдээллийн хөтөч” багийн гишүүдийн хэрэгцээнд зориулан ашиглах, сургалтын хичээлээр хийгдсэн гарын авлага товхимлыг боловсруулж хэвлүүлэн, ашиглаж байна.
- ОНХС-ийн “Иргэний хяналтын зөвлөл”, Мэдээллийн хөтөч” баг-аас ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх /ОНХС-д иргэдийн оролцоог хангах/ журам, аргачлалыг боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

ОНХС-нд иргэдийн оролцоог хангах талаар:

- Сумын удирдлагууд ОНХС-ийн талаар санал хүсэлтийг сонсох, санал асуулга авах, мэдээлэл хүргэх ажлыг хөдөө багийн айл өрх бүрд хүргэх ажлыг анх удаа зохион байгуулж хөдөөгийн 4 багийн бүх айл өрхүүдээр очиж ажилласан.
- ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, мэдээллийн ил тод байдлыг хангах сэдвээр иргэдийн дунд хэлэлцүүлэг явуулах ажлыг анх удаа хэрэгжүүлсэн.
- ОНХС-ийн үйл ажиллагааны мэдээллийн самбарыг хийлгэж, баг тус бүрийн Иргэний оролцооны танхимд байрлуулж, мэдээлэл хүргэж байна.
- ОНХС-ийн талаар иргэдийн санал асуулгаар өгсөн санал, хүсэлтийг орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүргэх боломж бий болгох ажлаар 75 иргэнээс гаргасан санал, хүсэлтийг нэгтгэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.



Хөвсгөл Аймгийн Төмөрбулаг сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хийх, мэдээлэл хүргэх үйл явц

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

УИХ-ын Тамгын Газар, ШХА, НҮБХХ-өөс “ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт төсөл”-д 3 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

ХҮРСЭН ҮР ДҮН

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын дэмжлэгт талаар иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлж, төрийн байгууллага, иргэдийн мэдээллийн эргэх холбоог сайжруулан, “Мэдээллийн хөтөч”-ийн багийг бэлтгэж, ОНХС-ийн төсвийн хэрэгжилтийн үе шат бүрд нь хяналт, үнэлгээ хийх “Иргэний хяналтын сайн дурын зөвлөл” буюу /Иргэний аудитын баг/ сум, багийн түвшинд байгуулсан. Иргэдийг чадавхжуулах ажлыг холбогдох сургалтын байгууллагаар дамжуулан зохион байгуулж, ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх журам, аргачлалыг боловсруулж, ИНХ-ын болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Хяналт үнэлгээ хийж байгаа орон нутгийн иргэд өмнөх ОНХС-ийн хөрөнгийн ажилд оролцож байсан учраас сайн ач холбогдол өгч чадахгүй байх хандлага гарсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо хяналт төслийн сургалтад иргэдийг төлөөлөн суусан. Энэ төсөл нь ОНХС-ийн талаар иргэдийн мэдээллийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой үр дүнтэй төсөл юм. Энэ төслийг хэрэгжүүлснээр иргэд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих журамтай гэдгийг ойлгон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл үр дүнтэй, үр өгөөжтэй болохыг ойлгосон. Цаашид сургалтад улам олон иргэдийг хамруулах шаардлагатай юм.

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын 5-р багийн иргэн Б. Уранмандал

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Иргэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй ажлын талаар мэдээлэлтэй болсон.

Иргэд ОНХС-ийн үйл ажиллагаа, хэрэгжилтийн үр дүнд хяналт хийх зорилгоор мэргэжлийн сургалтад хамрагдаж өөрийн мэдлэг, ур чадварыг сайжруулсан.

ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих үйл явц сайжирснаар төлөөллийн байгууллага үйл ажиллагаа явуулахад бодитой дэмжлэг болсон.

ОНХС-ийн үйл ажиллагаа, холбогдох хууль, журмын талаар мэдээ, мэдээллийг түгээх, иргэдэд цаг тухай бүрд мэдээлэх “Мэдээллийн хөтөч” багийг бэлтгэсэн нь хамтын ажиллагаа болоод хоорондын уялдааг сайжруулсан.

Хавсралт 1. Журам батлах тухай 45 дугаар тогтоол



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 45

Жаргалант

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт, 5, 6 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2, Сангийн сайдын 2018 оны 228 тушаалаар ОНХС-ийн журмын 5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад төлөөлийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан "Хяналттай төсөв-хариуцлагатай засаглал-хөгжлийн гарц" төслийн хүрээнд орон нутагт байгуулагдсан "Иргэний хяналтын зөвлөл"-өөс ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцооны хяналт, үнэлгээ хийх журам"-ыг, 1 дүгээр хавсралтаар, хяналт, үнэлгээ хийх маягтын загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг /сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Хурлын ажлын алба, багуудын ИНХ-ын Тэргүүлэгчид, Иргэний хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Бямбадорж/, ИТХ-ын /Тэргүүлэгч/ нарт даалгасугай.

ДАРГА

Б.БЯМБАСҮРЭН

Хавсралт 2. Иргэний хяналтын зөвлөл байгуулж “Мэдээллийн хөтөч баг ажиллуулах” тогтоол**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЖАРГАЛАНТ БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 02

Жаргалант

Г “Иргэний хяналтын зөвлөл” байгуулж, Г
“Мэдээллийн хөтөч баг” ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, 9 дүгээр зүйл, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Журам батлах тухай” 228 дугаар тушаалын хавсралтын 5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс орон нутгийн хөгжлийн сангийн хяналтын чиг үүргээр дэмжигдсэн “Хяналттай төсөв-хариуцлагатай засаглал-хөгжлийн гарц” төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор 1 дүгээр багийн иргэдийн Нийтийн Хурлын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багийн түвшинд Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд хяналт үнэлгээг хийх “Иргэний хяналтын зөвлөл”-ийг болон иргэдэд мэдээллээр хангах “Мэдээллийн хөтөч баг”-ийг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн “Иргэний хяналтын зөвлөл”-ийн болон “Мэдээллийн хөтөч баг”-ийн гишүүдийн баримтлан ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн “Иргэний хяналтын зөвлөл”-ийн болон “Мэдээллийн хөтөч баг”-ийг ажил зохион байгуулахад нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих дэмжлэг туслалцаа үзүүлж, иргэдийн оролцоонд тулгуурлан зөвлөлөөс гаргасан санал, санаачилга, шийдвэрүүдийг баг, орон нутгийн хөгжлийн бодлого, шийдвэрт тусган хэрэгжүүлж ажиллахыг /сумын ИТХ, Засаг дарга, төрийн болон төрийн байгууллага/-д санал болгосугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг хангуулж ажиллахыг багийн /ИНХ-ын дарга, Тэргүүлэгч/ нарт даалгасугай.

ДАРГА Н.ОЮУНБААТАР



3. Завхан аймгийн Их-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“445 ЦЭГТ ХҮРЭХ МАРШРУТ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Г.ЖАВЗАНСҮРЭН, Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-ын төлөөлөгч. 1982-1984, 1987-1993 онд Улаанбаатар хот АУИС-ийн нүүр амны ерөнхий мэргэжлээр төгссөн. 1980-1982 онд Их-Уул сумын хүүхдийн яслид үйлчилэгч, 1984-1987 онд Их-Уул сумын хүн эмнэлэгт сувилагч, 1993 оноос одоог хүртэл тус сумын ЭМТ-д эрхлэгч, их эмчээр 32 дахь жилдээ ажиллаж байна. 2016 оноос сумын ИТХ-ын Төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байгаа.

АГУУЛГА

Завхан аймгийн Их-Уул сумын 445 цэгт хүрэх замын урт, маршрутыг тогтоон төрийн үйлчилгээ үзүүлэхэд нэгдсэн стандарттай болсон.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд Эрүүл мэндийн төв болон бусад төрийн байгууллагууд нэгдсэн стандарт байдаггүй. Нэгдсэн стандарт байхгүйн улмаас сумын 445 цэгт очиход шатахууны төлбөрийг зөв тооцоолох боломжгүй байдаг. Өөрсдийн барагцаалсан тооцоогоор болон иргэдийн аман мэдээллээр замын уртыг тодорхойлон их бага янз бүрээр шатахуун хийж явдаг асуудлыг шийдвэрлэсэн.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Завхан аймгийн Их-Уул сумын төрийн үйлчилгээний байгууллага болон иргэд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 04 дүгээр сараас 05 дугаар сар хүртэлх хугацаанд.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Сумын 445 цэгт хүрэх замын урт, маршрутыг тогтоохдоо шаардлагатай цэгүүдийг нягталж баталгаажуулсан. Сумын газрын даамал, багийн Засаг дарга, БИНХ-ын дарга, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн идэвх оролцоог хангаж, тэдний санал хүсэлтэд тулгуурлаж, шаардлагатай тохиолдлуудыг нягталж үзсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Багийн Засаг дарга, багийн ИНХ-ын дарга, Газрын даамал, Эрүүл мэндийн төвийн саналыг үндэслэн Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон төрийн үйлчилгээ үзүүлэх маршрут замын уртыг тогтоож, албан байгууллагуудад хүргүүлэн тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон төрийн үйлчилгээ үзүүлэх, маршрут, замын уртыг тогтоохдоо баг тус бүрээс сонгогдсон ИТХ-ын Төлөөлөгч, багийн Засаг дарга, БИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийг оролцуулан цэг тус бүрд хүрэх замын уртыг, сумын газрын даамлаар солбицол /координат/-ыг тогтоосон.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Орон нутгийн төсөв, дотоод нөөц боломжоор уг ажлыг хийж гүйцэтгэсэн.



ХҮРСЭН ҮР ДҮН

- ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 сарын 04-ны өдрийн А/17 дугаар сумын 445 цэгт хүрэх замын урт, маршрутыг тогтоож, тогтоолоор баталсан.
- Сумын төв /Баян-Ухаа баг/-өөс Өвөлжөө, хаваржаа бүхий 445 цэгийн замын уртыг тогтоож баталгаажуулсан.
- Үүний дагуу эмнэлгийн түргэн тусламж, болон бусад төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд замын уртыг тооцож шатахуун олгож байгаа.
- Уг тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласнаар төсвийн байгууллагын шатахууны зардалд тавих хяналт сайжирч төсвийн үр ашиг дээшилсэн.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Уг ажлыг хийж гүйцэтгэхэд ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгараагүй.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон төрийн үйлчилгээг үзүүлэх маршрут замын урт”-ыг тогтоосноор байгууллагуудын шатахууны зардалд хэмнэлт гарч төсвийн зарцуулалт сайжирсан. Мөн байгууллагын дарга, эрхлэгч нар тухайн цэгт хүрэхэд харилцан адилгүй замын уртыг өөр өөр тооцож байсан явдал арилсан.

ЭМТ, ЗДТГ-ын нягтлан бодогч П.Норжинлхам

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Сумын хэмжээнд төрийн байгууллагын үйлчилгээ үзүүлэх 445 цэг буюу бүс нутгийн замын урт тодорхой болсон.

Бүс нутаг болоод замын урт тодорхой болсноор түүнд зарцуулах шатахуун, төсөв мөнгөний асуудал илүү нарийн тодорхойлогдох болсон.

Зөвхөн төрийн байгууллагын үйлчилгээнд ашиглах бус бүх төрлийн ажилд 445 цэгийн маршрутыг ашиглах боломжтой.

445 цэгийн маршрут тодорхой болсон нь замаас төөрч хугацаа болон санхүүгийн хувьд илүү зардал гарах эрсдэл буурсан.

Хавсралт 1. Иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон төрийн үйлчилгээ үзүүлэх маршрут замын уртыг тогтоох тухай А/17 дугаар тогтоол



4. Хэнтий аймгийн Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ОРОН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ААНБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Б.БАЯНСУВД, Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ийн нарийн бичгийн дарга. Төрийн захиргааны удирдлагаар мэргэшсэн. 2005 оноос одоог хүртэл Мөрөн сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албыг хашиж байна.

Холбоо барих утас: 93014448

Цахим хаяг: bayansuwdbanzragch46@gmail.com

АГУУЛГА

Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-аас орон нутагт уул уурхай, хайгуул, нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд чиг үүргийн хүрээнд хяналт тавих.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Сумын ИТХ-аас хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг компанийн үйл ажиллагаанд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай гарсан. Хэнтий аймгийн Мөрөн сумын 4 багийн нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалт, хайгуул, нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 19 компанид хяналт шинжилгээний ажил явуулахад зохих мэдлэг аргачлал байхгүйн улмаас хурлын байгууллагаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж чаддаггүй байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ын төлөөлөгчдийг хамруулсан нь.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017-2019 онуудад хэрэгжүүлсэн.


АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

ИТХ-ын төлөөлөгчдөд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болох үүднээс чадавхжуулан, түүгээр дамжуулан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- “ИТХ-ын төлөөлөгчдийг олборлох салбарт хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар мэдлэг олгох “сургалт” зохион байгуулсан. Ашиглалтын 1, хайгуулын 1, нөхөн сэргээлтийн 1. чулуу бутлуурын 1 лицензтэй компанийн үйл ажиллагаанд “хяналт шинжилгээний ажил” хийгдсэн.
- Сумын газар нутаг дээрх уул уурхайн талбайн байршил, орон нутгийн тусгай хамгаалалттай газар, уст цэг, түүх соёлын дурсгалт газар өвөлжөө хаваржааны нутгийг харуулсан “газрын зураг” гаргаж иргэдэд сурталчлан танилцуулсан.
- ИТХ-аас хяналт тавих журам боловсруулж батлуулсан.

- Журмын төслөөр иргэдийн дунд хэлэлцүүлэг, сонсох ажиллагаа явуулсан. Нөлөөлөл сурталчилгааны ажлын хүрээнд Хэнтий мэдээ сонин болон цахим хуудсаар сурталчилсан. Төслийн үйл ажиллагааг сурталчилсан “гарын авлага” хэвлүүлсэн.



Хэнтий аймгийн Мөрөн сумын газрын зураг. Зурагт хайгуул, ашиглалтын тусгай хамгаалалттай газрыг тэмдэглэхээс гадна орон нутгийн болон тусгай хамгаалалттай газрыг тэмдэглэсэн байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

УИХ-ын тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр "Монгол улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж Хэнтий аймгийн мөрөн сумын "ИТХ-ын төлөөлөгчдөд хяналт хийх чадавхыг нэмэгдүүлэх нь" төслийг санхүүжүүлсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- ИТХ-ын төлөөлөгчид уул уурхайн салбарт хяналт үнэлгээ хийх ажлын арга зүйд суралцсан.
- Төслийн хүрээнд мөрөн сумын үйл ажиллагаа явуулдаг Ашиглалтын 1, хайгуулын 1, нөхөн сэргээлтийн 1. Чулуу бутлуурын 1 лицензтэй компанийн үйл ажиллагаанд "ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ" хийж энэ ажлын хүрээнд тодорхой санал дүгнэлт зөвлөмжийг тухайн компаниудад хүргүүлсэн.
- Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулдаг компанийн хяналт үнэлгээ хийх үнэлгээний үзүүлэлтийг төслийн багийн гишүүд бие даан боловсруулсан.
- ИТХ орон нутгийн компаниудын харилцаа хамтын ажиллагаа сайжирсан.
- ИТХ-аас хяналт тавих журам боловсруулж батлуулсан. Журмын хүрээнд 2018-2019 онд Бэрх уул ХХК-ны нүүрсний уурхай, хайрга олборлолтын Харгуй ТӨУҮГ-ийн үйл

ажиллагаанд тусгай аргачлалын дагуу хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулсан.

- Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих журмыг батлан гаргасан.
- Сумын газар нутаг дээрх уул уурхайн талбайн байршил, орон нутгийн тусгай хамгаалалттай газар, уст цэг, түүх соёлын дурсгалт газар өвөлжөө хаваржааны нутгийг харуулсан **“ГАЗРЫН ЗУРАГ”** гаргаж иргэдэд сурталчлан танилцуулах зорилгоор хийсэн. Газрын зурагт 6 ашиглалтын талбай, 13 хайгуулын талбай, түүх соёлын 217 газар, аймаг сумын орон нутгийн хамгаалалтад авсан газрууд малчдын өвөлжөө хаваржааны газруудыг тусгасан.



Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ын төлөөлөгчид орон нутагт үйл ажиллагаа явуулж буй “Блю Гоулд” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж буй үйл явц.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Хяналтын зөвлөлийн багийнхны хяналт шинжилгээ хийх, үр дүн тайлан гаргах, зөвлөгөө зөвлөмж хүргүүлэх чадвар хангалтгүй, уул уурхайн мэдлэг дутмаг байсан. Мөн газрын зураг дээр тэмдэглэгдэж байгаа түүх дурсгалт газрын солбицол тэмдэглэхэд хүндрэлтэй байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд уул уурхай ашиглалт, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, өвөлжөө хаваржааг тэмдэглэсэн газрын зурагтай болж түүнийгээ малчин өрх бүрээр орж тайлбарлан таниулсанд талархалтай байна. Бид өвөлжөө хаваржаа нүүдэл суудал, хадлан тариалан хийхэд газрын маргаан үүсдэг энэ асуудал ч мөн шийдэгдэж байна. Бас уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудад шалгалт хийж хяналт тавьж байгаа нь нөхөн сэргээлт, хашаа хамгаалалт гээд малын бэлчээрт үр дүнгээ өгнө гэж бодож байна аа.


Хэнтий аймгийн Мөрөн сумын малчин Э.Баянмөнх

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

ИТХ-ын төлөөлөгчид болон орон нутгийн иргэд орон нутгийн бүс нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын үйл ажиллагаанд хяналт тавих болсон.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ыг хууль тогтоомжийн дагуу ажиллахыг шаардаж байгаль орчны хамгаалахад хувь нэмрээ оруулж байна.

Мөрөн сумын газрын зурагтай болсноор хайгуул ашиглалтын тусгай хамгаалалтыг тэмдэглэх, үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад хяналт тавих бүрэн боломжтой болсон.



Хавсралт 1. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих журам батлах тухай



**ХЭНТИЙ АЙМАГ
МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТАВДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 06 өдөр Дугаар 08 Мөрөн

Г Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаархи
хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт
тавих журам батлах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 хэсэг, газрын хэвлийн тухай хуулийн 8.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дах хэсгийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Мөрөн суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд "Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай
2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын тэргүүлэгчид-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭНХСҮХ



Хавсралт 2. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих журам

Хэнтий аймгийн Мөрөн сумын ИТХ-ын
2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн
3. 02 дугаар тогтоолын хавсралт

**Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх хууль тогтоомжийн
хэрэгжилтэд хяналт тавих журам**

1. Энэ журмын зорилго нь нутаг дэвсгэртээ хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүднээс газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, газрын хэвлий болон ашигт малтмал ашиглах, хамгаалах талаар сумын ИТХ-аас гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оршино.
2. Энэ журам нь Газрын хэвлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 \12.1.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих; дахь хэсэгт нийцсэн байна.
3. Энэ журмыг зохих хууль тогтоомжийн дагуу газрын хэвлийг ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.
4. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хэсэг буюу хяналтын зөвлөл /цаашид хяналтын зөвлөл гэх/-ыг сумын ИТХ-ын тэргүүлэгчдээс томилно.
5. Хяналтын зөвлөлийг 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд сумын ИТХ-ын байгаль орчин хөдөөгийн хөгжлийн асуудал хариуцсан хорооны дарга ахлана. Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд төсөв, санхүүгийн асуудал хариуцсан Тэргүүлэгч гишүүн, байгаль орчин хөдөөгийн хөгжлийн асуудал хариуцсан хорооны гишүүн, сумын Засаг даргын орлогч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, газрын даамал, байгаль орчны байцаагч, иргэдийн төлөөлөл оролцсон байна.
6. Хяналтын зөвлөл нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах чиглэлээр хяналтын үйл ажиллагааг явуулна.
 - а/ нутаг дэвсгэр дэх газрын хэвлий ашиглагчдын зүгээс геологийн хайгуул, ашигт малтмал зохистой ашиглах, байгаль орчин, газрын хэвлийг хамгаалах талаарх хууль тогтоомж, стандарт, нормативын баримт бичгийн шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэх
 - б/ уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаанаас шалтгаалан газрын хэвлийд эвдрэл, доройтол үүссэн, хими, биологийн бодис, үйлдвэр, ахуйн хог хаягдлаар бохирдсон эсэхэд хяналт тавих
 - в/ газрын хэвлийд учирсан хохирол нь хүн ам, байгаль орчин, дэд бүтэц, барилга байгууламжид сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих
 - г/ газрын хэвлийг ашиглах тусгай зөвшөөрөл, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байгаа эсэх
 - д/ хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах дараах баримт бичгийн бүрдлийг газар дээр нь хянах:

- хайгуулын тусгай зөвшөөрөл;
 - байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан;
 - гадаадын иргэдийг ажиллуулж байгаа бол тэдгээрийн ажилуулах зөвшөөрөл, тоо.
- е/ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах дараах баримт бичгийн бүрдлийг газар дээр нь хянах:

- ашиглалтын тусгай зөвшөөрөл;
- ашигт малтмал ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө;
- байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- байгаль орчны менежментийн төлөвлөгөө;
- хөрөнгө түрээслэх болон бүтээгдэхүүн борлуулах гэрээ;
- уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан акт;
- газар, ус ашиглах тухай гэрээ;
- гадаадын иргэдийг ажиллуулж байгаа бол тэдгээрийн ажилуулах зөвшөөрөл, тоо.

ж/ байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлсэн эсэх

з/ гадаадын иргэдийг тогтоосноос илүү хэмжээгээр /Ашигт малтмалын тухай хуулийн 43.1/ авч ажиллуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь илүү ажлын байрны төлбөрийг сумын төсөвт сар бүр төлж байгаа эсэх

и/ тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад газрын хэвлий ашиглагч нар нь /үүнд ердийн ашигт малтмал ашиглагч орно/ үйл ажиллагаа явуулахдаа тухайн ашиглалтын зориулалтаар зохих зөвшөөрлийг авсан эсэх

к/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, цэвэрлэх байгууламж, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглахад шаардагдах дараах баримт бичгийн бүрдлийг газар дээр нь хянах:

- газар эзэмших, ашиглах эрхийн бичиг;
- шаардлагатай бол газрын хэвлий ашиглах зөвшөөрөл;
- тухайн барилга, байгууламжийг барьж байгуулах төсөл, техник эдийн засгийн үндэслэл;
- байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- байгаль орчны менежментийн төлөвлөгөө;
- ус ашиглах гэрээ.

л/ газрын хэвлийг ашиглах зөвшөөрөл нь өвөлжөө, хаваржааны доорх газар, гэр хашаа, хүнсний ногооны гэх мэт эзэмшилт, ашиглалтад олгогдсон газрын эрхийг зөрчиж давхцал үүсгэж байгаа эсэх

м/ газрын хэвлийг хууль бусаар ашигласан үйлдэлд зөрчлийн тухай хууль тогтоомж, бусад хууль тогтоомжийн дагуу тавигдсан торгууль, нөхөн төлбөр, захиргааны арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх

н/ газрын хэвлийг ашигласны дараа холбогдох техникийн баримт бичгийн дагуу байгаль орчны нөхөн сэргээлт хийсэн эсэх

7. Хяналтын зөвлөл нь хяналтын үйл ажиллагаа явуулахдаа шаардлагатай тохиолдолд сумын нутаг дэвсгэрт байгаа мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, ажилтнуудыг дайчлан ажиллуулж болно.

8. Хяналтын зөвлөл нь байгаль орчны нөхөн сэргээлт хийсэн газрыг сум орон нутаг хүлээн зориулсан албан ёсоор оролцоно.

10. Хяналтын зөвлөл нь хяналт явуулах бүрдээ зөрчил илэрсэн эсэхээс үл хамааран явцын тухай тэмдэглэл хөтөлж уг үйл ажиллагаанд оролцсон гишүүн бүр гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

5. Завхан аймгийн Их-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙХ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНД ХЯНАЛТ ТАВИХ НЬ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

И. ЭНХТҮВШИН, Завхан аймгийн Их Уул сумын ИТХ-ын дарга. Багш мэргэжилтэй. 1996-1999 онд Завхан аймгийн Их-Уул сумын Хуягт багийн засаг дарга, 1999-2003 онд Завхан аймгийн Их-Уул сумын Хуягт багийн бага сургуулийн багш, 2004-2016 онд Завхан аймгийн Их-Уул сумын ХАА-н цаг уурч, 2016 оноос Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-ын даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 89798808,

Цахим хаяг: enkhtuwshin.i1006@gmail.com

АГУУЛГА

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бараа, ажил үйлчилгээний талаар нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, тус ажилд иргэдийн зүгээс хяналт тавьж ажилласан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Завхан аймгийн Их-Уул сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил, бараа үйлчилгээний талаар иргэдийг мэдээлэлтэй болгох, ажил, бараа үйлчилгээг чанартай хийлгэхэд хяналтгүй байна.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хяналт тавих иргэдийн ажлын хэсэг.
- Гүйцэтгэгч /иргэдийн бүлэг, аж ахуйн нэгж/
- Засаг даргын Тамгын газар буюу захиалагч

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 10 сараас 2019 оны 7 сард хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Орон нутгийн иргэдийн зүгээс хөндлөнгийн хараат бус хяналт шинжилгээг хийсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

Тогтвортой амьжиргаа-3 төслийн Завхан аймаг дахь орон нутгийн зохицуулагч сум орон нутагт иргэд, төрийн албан хаагч нарт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилд хяналт, шинжилгээ хийх талаар сургалт зохион байгуулсан.

Нутгийн идэвх санаачилга иргэдийг өөрсдийн саналыг нь харгалзан “Иргэдийн ажлын хэсэг”-ийг байгуулсан. ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2019 оны 7 сарын 22-ны өдрийн А/22 дугаар тогтоолоор идэвх санаачилгатай сайн ажиллаж байгаа иргэдийг оролцуулан шинэчлэн байгуулсан.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Ажлын хэсгийг хяналт, шинжилгээ хийх ажилд шаардагдах шатахуун, бичиг хэрэг, цай хоол зэрэг бусад шаардлагатай зардлыг сумын ИТХ-ын төсвөөс санхүүжүүлсэн. “Тогтвортой амьжиргаа-3” төслийн орон нутгийн зохицуулагчид хүсэлт хүргүүлэн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Нийт зардал-900 000 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна.

ХҮРСЭН ҮР ДҮН

Ажлын хэсэгт оруулах иргэдийг БИНХ-д хүсэлт хүргүүлэн тухайн хурлаас санал болгосон баг тус бүрийн төлөөлөл бүхий 18 гишүүнтэйгээр байгуулсан. Уг ажлын хэсэгт сумын ИТХ-ын Төлөөлөгч болон төрийн албан хаагчдын төлөөллийг оролцуулалгүйгээр байгуулсан нь хараат бусаар ажиллаж ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний чанар хүртээмж сайжирсан.

Сумын ОНХС хариуцдаг албан хаагчид болох Засаг даргын орлогч, Санхүү тасгийн дарга нараа Тухайн жилийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг “Иргэдийн ажлын хэсэг” танилцуулга хийлгүүлж, мэдээллээр хангах ажлыг хийдэг. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд “Иргэдийн ажлын хэсэг” хяналт шалгалт хийж дүгнэлт гаргаж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж ажиллаж байгаа. Үүний үр дүнд иргэд өөрсдөө мэдээлэл сайтай болж ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн чанаргүй ажлыг зогсоох, үлдсэн санхүүжилтийг олгохгүй байх, сайн хийгдсэн ажлыг иргэдэд мэдээлж ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Хүндрэл бэрхшээл байхгүй.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, гүйцэтгэгчид зовломж, дүгнэлт хүргүүлэн ажиллаж байгаа нь гүйцэтгэгч болон нийлүүлэгчийн ажил үйлчилгээ, барааны чанар сайжрахад нөлөөлж байна. Мөн иргэдийн идэвх оролцоо, хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.

Завхан аймгийн Их-Уул сумын иргэн Г.Бавуусүрэн, Н.Баатармаа

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Иргэд, төрийн албан хаагчид ОНХС-ийн талаар мэдээлэлтэй болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг иргэд шаардах болсон.

Иргэд ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ цаашид үйл ажиллагааг сайжруулахад саналаа тусгасан.

6. Баянхонгор Заг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“НУТГИЙН ХӨГЖИЛ-ИРГЭДИЙН ХЯНАЛТ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Т.НЯМЖАРГАЛ, Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын дарга.

Эрхзүйч мэргэжилтэй. 2011-2015 онд төслийн менежерээр ажиллаж байсан. 2016 оны ээлжит сонгуулиар Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Холбоо барих утас: 88112734

АГУУЛГА

Иргэдийн оролцоотой ИТХ-ын хяналтыг бий болгож ажиллах чиглэлээр “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “Нутгийн хөгжил-иргэдийн хяналт” дэд төслийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол улсад Төсвийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш ОНХС бий болж, орон нутгийн иргэд өөрсдийн амьдран суугаа нутгийн хөгжилд өөрсдийн хувь нэмрийг оруулах, өөрсдийн эрх мэдлээр зарцуулах орон нутгийн хөгжлийн сангийн төсөвтэй болсон билээ. Гэвч Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнд иргэдийн оролцоотой хяналт шинжилгээ үнэлгээ хийгдэхгүй байна. Мөн иргэд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд хяналт тавих, үнэлгээ хийх боломжтойгоо мэддэггүйгээс тухайн ажил гүйцэтгэгч орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлаа чанаргүй хийх, баталгаагүй, хариуцах эзэнгүйдэх, танил талдаа өгөх, хийсэн нэр хэмээх, материалын үнийг хэт өндөр үнээр үнэлэх зэрэг сөрөг үр дагавар гардаг. Ард иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа зарим ажлын талаар өөрсдийн ашиглалт, мэдээлэл, харсан зүйлээ холбогдох байгууллага, удирдлагад хэлдэг боловч цаасан дээр баталгаажуулаагүйгээс ач холболдолгүй болж, шийдвэрлэгдэхгүй байх нь энэ хөрөнгийг үнэгүйдүүлэх явдал нь тулгамдсан гол асуудал байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

ЗДТГ, ИТХ, ЭМТ, ЕБС, Соёл мэдээллийн төв, цэцэрлэг, спорт заал, сумын төвийн цэцэрлэгт хүрээлэн, хогийн машиныг ашигласан иргэд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017, 2018, 2019 онуудад хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Иргэдийн оролцоотой ИТХ-ын хяналтыг бий болгож ажиллах чиглэлээр “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “Нутгийн хөгжил-иргэдийн хяналт” дэд төслийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- “Нутгийн хөгжил-Иргэдийн хяналт” дэд төслийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилд хяналт үнэлгээ хийх ИТХ-ын дэргэдэх “Хяналтын хороо”-г шинэчлэн байгуулж, ажиллах журмыг батлан, хяналтын хорооны гишүүдийг сургалтад хамруулж чадавхжуулсан.
- Хяналтын хороо нь 2017 оны 4 ажил, 2018 оны 8 ажил, 2019 оны 4 ажилд үнэлгээ хяналт-шинжилгээ-үнэлгээ хийж ИТХ-д зөвлөмж хүргүүлсний дагуу Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн 3 удаа тус тус хяналт шалгалтыг хийсэн.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардагдах төсвийг тухайн жилийн ИТХ-ын төсөвт тусгуулж үйл ажиллагааг дэмжсэн. Нийт 5 сая төгрөг зарцуулсан.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт, хяналтад олон нийтийн оролцоог хангах чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийг ажлын тусгай ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн.
- Хяналтын хорооны бүх гишүүдийг 2019 оны төсөв Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт батлах хурлын хуралдаанд суулгаж ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын талаарх мэдээллээр бүрэн хангасан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүх ажил дээр хяналт, шинжилгээ, үнэлгээ хийснээр тухайн ажил үйлчилгээ чанартай техникийн тодорхойлолтын дагуу хийдэг болсон.
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд санал өгч хийгдэх ажлын жагсаалтад эрэмбэлэн тусгуулах, хэрэгжилтэд үнэлгээ хийх хяналт тавих бүрэн боломжтойг ард иргэд бүрэн ойлгосон. Сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороогоор ОНХС хөрөнгөөр хийгдэж байгаа болон хийгдсэн ажилд хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг тогтмол хийлгэдэг болсон.
- Сумын Засаг даргын тамгын газраас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа болон хийгдсэн ажлын талаарх тайланг ард иргэдэд нээлттэй, ил тод мэдээллээр бүрэн хангадаг болсон.
- Ард иргэдийг мэдээллээр хангаж, идэвх оролцоог сайжруулах ИТХ-д хяналт тавих зорилгоор Хяналтын ажлын хэсэг ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд хяналт үнэлгээ хийхэд үнэлгээний багийн гишүүд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл муу, холбогдох төрийн албан хаагчдаас мэдээлэл цуглуулах, бичиг баримт авахад үл ойлголцол гарах зэрэг бэрхшээл тулгарч байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

ОНХС-аар хийгдэх ажлын талаарх мэдээлэл, үнэлгээ хийхэд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтаар тухайн суманд хийгдэж буй төсөв нь сэрэнэ гэсэн хувьцааг төсөвтөө бодитой хэрэгжиж байгааг үнэн зөвөөр дүгнэж сум орон нутгийн үйл ажиллагаа цэгцэрч чанар сайжирч байна. Ингэснээр ОНХС-аар хийгдэж байгаа ажилд өөрсдийн санаа бодлоо тусгах, анхаарах зэрэг сайн талууд бий болж байна.

Баянхонгор аймгийн Заг сумын иргэн Т.Мөнхцэцэг

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

ИТХ-ын дэргэдэх "Хяналтын хороо"-г байгуулж, багийн гишүүд ОНХС, СХС-ийн талаарх мэдээлэлтэй болсон.

Тогтоол, шийдвэрийн нийцэл болоод хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, үр дүнг хэлэлцдэг болсон.

Хяналтын хорооны үйл ажиллагаагаар дамжуулан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа болон хийгдсэн ажлуудад хяналт тавьснаар цаашид улам эрчимжүүлэх боломжийг бий болгосон.

Хавсралт 1. "ОНХС-ийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих" хяналт-шинжилгээ, үнэлгээний журам

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
11/01 дүгээр тоот тогтоолын хавсралт

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛД
ТАВИХ "ХЯНАЛТЫН-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ"**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлд "Иргэний хяналт" тавих үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө

1.2 ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь сумын нутаг давсгэрт төрийн хөрөнгөөр хийгдэж буй ажил үйлчилгээний гүйцэтгэл, тоо чанар, аюулгүй байдалд хяналт тавих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх ард иргэдэд зөв мэдээллийг хүрэх бусдын нөлөөлөлд үл автах, ашиг сонирхол үүсгэхгүй байх, шударга ёс хууль дээдлэх зарчмыг баримталж ажиллана.

1.3 "Хяналтын-шинжилгээ, үнэлгээ"-ний журам нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэгдэж баталгаажсан байна.

Хоёр. Хяналтын хорооны бүтэц, зохион байгуулалт

2.1 Хяналтын хороонд тухайн гүйцэтгэх ажлын чиглэлээр мэргэжил, ажлын туршлага, мэдлэгтэй иргэн байх бөгөөд нь 11-16 хүний бүрэлдэхүүнтэй байна

2.2 Хяналтын хорооны гишүүдийг тухайн багийн иргэдээс судлан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс сонгосон буюу иргэд сайн дураар сонгогдсон байна

2.3 Хяналтын хорооны гишүүд нь ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор чиг үүрэг болгосон үйл ажиллагаанд хяналт тавина

2.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүрт Хяналтын хорооны гишүүдийн бүрэлдэхүүн өөрчлөгдөж болно

2.5 Хяналтын хороо нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүрт тайлан бичиж, тэмдэглэл хөтөлөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнана.

Гурав. Хяналтын хорооны эрх үүрэг

3.1 Хяналтын хороо нь төрийн мөнгөөр гүйцэтгэгдэж буй бараа, ажил үйлчилгээний чанар, тоо хэмжээ, аюулгүй байдалд хяналт хийнэ.

3.2 Хяналтын хороо нь хөрөнгө оруулалтын ажлын явцын гүйцэтгэлд "хяналт-шинжилгээ", харин хөрөнгө оруулалтын ажил нь ашиглалтанд ороод комисс хүлээх

авсан ажилд “үнэлгээ” хийж тайлан бичиж, тэмдэглэл хөтөлөн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнана.

3.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад гарсан зөрчил, дутагдлыг ИТХ-ын Тэргүүлэгчид хэлэлцэж зөрчлийг арилгуулах тогтоол, шийдвэр гарган Засаг даргад үүрэг чиглэл болгоно.

3.4 Хяналтаар илэрсэн зөрчил, дутагдал авсан арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хуульд нийцүүлэн мэдээлнэ.

3.5 Төрийн мөнгөөр бараа ажил гүйцэтгэж буй байгууллага, этгээдийг зөрчлөө арилгасан талаарх мэдээллийг шаардах эрхтэй

3.6 Тухайн хийгдэж буй ажлын газар олголтын захирамж, гэрчилгээ хүчин төгөлдөр эсэх, техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авсан эсэхийг нарийвчлан үзэх эрхтэй

3.7 Ажлын зураг төслийг батлагдсан хуваарийн дагуу боловсруулсан байдал, хуулийн дагуу зураг төлөвлөлтөд бүрэн магадлал хийгдсэн эсэхийг үзэж, гаргасан дүгнэлтүүдтэй танилцах эрхтэй

3.8 Тухайн ажлыг эхлэхдээ мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авсан эсэхийг шалгах эрхтэй

3.9 Ажлын явцад чанар байдлын талаар тодорхой мэдээллийг зураг төсөл болон мэргэжлийн хяналтын байгууллагаас лавлаж тодруулах эрхтэй

3.10 Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналт бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт хийх эрхтэй

3.11 Тухайн багийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа ажилтай холбоотой мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас авч байна

3.12 Хяналтын хорооны гишүүн нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүртээ ашиг сонирхолын мэдүүлэг бөглөж байна.

3.13 Хяналтын хороо нь хяналт тавьж ажилласан тайлан, мэдээллийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд тухай бүр ирүүлж байна

3.14 Орон нутагт хийгдэж байгаа 10 саяас дотогш тендер зарлагдаагүй ажил 10 саяас дээш тендер зарлагдсан ажил тус бүр дээр хяналтын хороо чиг үүргийнхээ дагуу ажиллана.



1. Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ХҮҮХДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

С.ГАНТӨГС, Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга. Хувцас загвар зохион бүтээгч инженер, төрийн удирдлагын менежер мэргэжилтэй. Төв аймгийн Хүүхдийн төлөө төвийн хүүхдийн ордны зохион байгуулагч. Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн ажлын албаны дарга.

Холбоо барих дугаар: 99062943

Цахим хаяг: Gantugssodoo@gmail.com

АГУУЛГА

Хүүхэд залуучуудын сайн дурын үйл ажиллагааг дэмжих замаар нийгмийн идэвхийг сайжруулах, үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх үйл явцад сургах.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хүүхэд багачуудыг сайн үйлсийн аянд оролцох оролцоог нэмэгдүүлэх, сайн дурын үйл ажиллагааны мөн чанар, ашиг тусыг ойлгуулах. Тэдний хийсэн ажлыг баталгаажуулан үнэлэх. Тиймээс ажиллах журмыг боловсронгуй болгож эрх зүйн орчныг бий болгож өгөх нь асуудал тулгамдаж байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Төв аймгийн хүүхэд залуучуудыг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 03 сарын 27-ны өдрөөс 2020 оны 03 сарын хүртэл тасралтгүй үргэлжилсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Сайн дурын үйл ажиллагааг орон нутагт бий болгосноор хариу нэхээгүй аяныг өрнүүлэх, өсвөрийн хүүхэд багачуудыг энэрэнгүй нинжин сэтгэлтэй болж төлөвших, цаашилбал гадаад, дотоодын их дээд сургуульд суралцахад нь нийгмийн сайн дурын оролцоонд оролцож байсан үнэлэмжийг дээшлүүлэхэд чухал юм. Тиймээс ажиллах журмыг боловсронгуй болгож эрх зүйн орчныг бий болгосон.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Төслийг хэрэгжүүлэхээс өмнө сайн дурын оролцооны ач холбогдлын талаар судалсан,
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг сайн дурын байгууллагын үйл явцтай танилцаж туршлага судалсан,
- “Сайн дурын оролцооны журам”-ын төсөлд мэргэжилтнүүдээс санал авч, саналыг тусгасан,
- Орон нутгийн ЕБС-ын нийгмийн ажилтнуудтай уулзаж тэдний саналыг авсан,
- “Сайн дурын оролцооны журам”-ын төслийг боловсруулан тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.
- “Сайн дурын оролцооны журам”-ын төслийг олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг хийсэн,

- Сайн дурын ажилд орж ажиллах хүүхдүүдийг сургалтад хамруулсан,
- Сургуулиудын нийгмийн ажилтнуудад журмыг хувилж өгч сургуулийн хүүхдүүдэд танилцуулж сурталчлуулсан,
- Сайн дурын ажилд оролцох хүүхдүүдийн саналыг авсан. Сайн дурын ажилтнуудаар хийлгэх ажлын саналыг гарган төлөвлөгөө боловсруулан ажилласан.



Төв аймгийн Зуунмод сумын хүүхэд, залуучуудын сайн дурын үйл ажиллагаанд оролцох үйл явц

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Туршлага судлах хөтөлбөрийн оролцогчид өөрсдөө зардлаа шийдвэрлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

Сайн дурын үйл ажиллагааны журам болон баталгаажуулах сертификаттай болсноор хүүхэд залуучууд, иргэд сайн дурын ажлын үнэ цэнэ, мөн чанарыг ойлгож, сайн дурын ажил хийх хүсэл эрмэлзэл нэмэгдсэн. Сайн дурын үйл ажиллагааг орон нутагт бий болгосноор хариу нэхээгүй аяныг өрнүүлэх, өсвөрийн хүүхэд багачуудыг энэрэнгүй нинжин сэтгэлтэй болж төлөвших, цаашилбал гадаад, дотоодын их дээд сургуульд суралцахад нь нийгмийн сайн дурын оролцоонд оролцож байсан үнэлэмжийг дээшлүүлэхэд чухал юм. Сайн дурын ажил хийж буй байгууллагуудтай холбогдож тэдний туршлагыг судалснаар сайн дурын ажлын үр шим олон давуу талуудыг гаргаж, өргөн хүрээнд хийх боломжийг бий болгосон.

Сурагчид төрийн байгууллагуудтай хамтран сайн дурын ажил хийснээр тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох ашиг тустай байсан.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Хэрэгжүүлэхэд тулгамдсан бэрхшээл байхгүй.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Би өмнө нь хичээлээс гадуур ямар нэгэн үйл ажиллагаанд оролцдоггүй байсан. Манай суманд гадаадаас 2 сайн дурын ажилтан ирээд бид нарт сайн дурын ажил гэж юу болох ямар ашиг тустайг хэлж өгсөн. Түүний дараагаар бид нар Улаанбаатар хотод НҮБ болон бусад байгууллагууд дээр очиж сайн дурын ажилтан гэж хэн болох, сайн дурын ажил хийх нь ямар ашиг тустай болох зэргийг мэдэж авч туршилага судалсан. Сайн дурын ажил хийж эхлэхэд сайн дурын ажилтан болсноор нэг айлд эсвэл нэг хүнд очиж туслаад түүнийг би хүнд тусалчихлаа гэж бодох биш юм байна лээ. Нийгмийн сайн сайхан, өөрчлөлтийн төлөө өөрийн хувь нэмрээ оруулах том боломж гэдгийг ойлгосон. Олон хүмүүстэй харилцах, өргөн хүрээний мэдээллийг олж авах түүнийгээ боловсруулах, найз нөхдийн хүрээгээ тэлэхээс гадна нийгмийн идэвхтэй болж гадаад хэлний мэдлэгээ ч дээшлүүлж чадсан. Хийсэн ажлыг маань баталгаажуулж сертификат олгож байгаа нь, бидний хичээл зүтгэлийг үнэлж, гадаадад суралцах боломжийг нээхэд тусалсан. Энэхүү хөтөлбөрт хамрагдаж энэ их боломжийг олж чадсандаа баяртай байна.

Герман, Hartnackschule сургуулийн оюутан Бямбазаяа

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн ЕБС-ийн хүүхдүүд нийгэм, хүмүүнлэгийн сайн дурын ажлын туршлагатай болж, нийгмийн асуудалд тэдний оролцоо чухал хувь нэмэр оруулах талаар ойлголцотой болсон.

Орон нутгийн иргэд болон хүүхдүүдийн нийгмийн идэвх оролцоо, санал санаачилга сайжирсан.

Хүүхдүүд өөрсдийн санаачилга, сайн дурын ажлын хүрээнд бусдад туслахын зэрэгцээ эерэг хандлагыг түгээсэн.

Хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө илэрхийлэх чадамж, бусдыг сонсох, хүндлэх, багаар ажиллах гэх мэт олон ур чадварт суралцсан.

Төрийн болон төлөөллийн байгууллага нь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд тэдний дуу хоолойг хүргэхэд ямар үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ шаардлагатай байгааг илүү сайн мэдэх боломж бүрдсэн.

Хавсралт 1. Сайн дурын оролцооны журам батлах тухай 38 дугаар тогтоол



ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ



2. Төв аймгийн Өндөрширээт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ЭМЭГТЭЙЧҮҮДДЭЭ ТУСАЛЪЯ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Ч. УРАНЧИМЭГ, Эмч мэргэжилтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч.

Эрүүл мэндийн төвд 36 дахь жилдээ ажиллаж байгаа.

Холбоо барих утас: 8803296,

Цахим хаяг: otgontsetseg0625@yahoo.com

АГУУЛГА

Төв аймгийн Өндөрширээт сумын ИТХ-ын дэргэдэх “Эмэгтэйчүүдийн бүлэг”-ийн гишүүд орон нутгийн өрх толгойлсон эмэгтэйчүүдэд туслах үүднээс “Юу байна түүгээрээ тусалъя аян”-ыг амжилтай өрнүүлсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Орон нутгийн өрх толгойлсон эмэгтэйчүүдэд төрийн байгууллага болон нийгмийн бусад байгууллагаас тэдний амьдрал ахуй, хувь хүний нийгмийн оролцоог дэмжсэн үйл ажиллагаа хомс байдаг.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Төв аймгийн Өндөрширээт сумын өрх толгойлсон эмэгтэйчүүд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 4-р сараас 2019 оны 4-р сар хүртэл хэрэгжсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Сумын ИТХ-ын дэргэдэх Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулж, эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлуудыг дэвшүүлж, сумын эмэгтэйчүүдэд “Эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэвт сургалт зохион байгуулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Эмэгтэйчүүдийн манлайлал сэдэвт сургалтад эмэгтэй төлөөлөгчид хамрагдаж, сургалтын үр дүнд эмэгтэйчүүдээс санал бодлыг нь сонсож, эмэгтэйчүүдийг бүлэг байгуулж ажиллах талаар анхны хурлаа хийж дарга, нарийн бичгийн даргаа сонгосон.
- Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулсан талаар ИТХ-даа албан ёсоор энэ талаар мэдэгдсэн.
- Эмэгтэйчүүдийн бүлэг хоёр дахь хурлаа 2018.11.15-нд хийж хийх ажлын төлөвлөгөөгөө гаргахын тулд багийн эмэгтэйчүүдийн төлөөллийг урьж хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулсан.
- Төлөвлөгөөний дагуу зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан.

- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Жаргалмаатай хамтран эмэгтэйчүүдийн баяраар эмэгтэй төлөөлөгч нарыг хүлээн авч уулзан, цаашид хийх шаардлагатай нэн чухал ажлын талаар ярилцсан.
- Эмэгтэйчүүдийн бүлгээрээ хийх ажлын төлөвлөгөө гарган багийн төлөөлөл болсон эмэгтэйчүүдээс өрх толгойлсон эмэгтэйчүүдээ тусалъя гэсэн уг санал гарсан. Тус саналыг төлөвлөгөөндөө тусган авсан.
- Сумын ИТХ-ын дэргэдэх эмэгтэйчүүдийн бүлэг нь “Юу байна түүгээрээ тусалъя аян”-ыг өрнүүлсэн
- Аяны хүрээнд цугларсан мөнгө, бараа хүнс, түлээ нүүрсийг өрх толгойлсон эмэгтэйчүүдэд гэрээр нь орж тарааж өгч тэдний саналыг сонсов.



“Юу байна түүгээрээ тусалъя аян”-ы үйл ажиллагааг зохион байгуулах үйл явц.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Эмэгтэйчүүдийн бүлгээс санаачилж хандиваар төсвийг босгосон. Мөн аймгийн ИТХ-ын төлөөлөгч Жаргалмаа 300000 төгрөг, эмэгтэй төлөөлөгч нар хувиасаа 180000 төгрөг гаргасан.

ХҮРСЭН ҮР ДҮН

Багийн Засаг дарга нараас баг бүрээс тусламж үйлчилгээ авах шаардлагатай 2-3 иргэний судалгааг гаргуулан нийт 7 өрх толгойлсон эхэд тусламж хүргэхээр аян өрнүүлсэн. Орон нутгийн иргэд сайн дурын аянд нэгдэж өрх толгойлсон эмэгтэйчүүдэд тусалсандаа, тэднийг баярлуулсандаа талархаж байсан. Мөн эмэгтэйчүүдэд өгсөн тусламжийн зүйл нь сэтгэлийн хандив байсан учраас их талархаж хүлээн авч байсан. Эмэгтэй гишүүд “Монфемнэт Үндэсний Сүлжээ”-нээс мэргэжил арга зүйн дэмжлэг авч, манлайллын сургалтад хамрагдаж өөрсдийн сурсан мэдсэн зүйлсээ сумын эмэгтэйчүүдийн хамтын ажиллагаа, эмэгтэйчүүдийн хөгжлийн төлөө ажиллахад ашиглан ажиллаж байна.

Эмэгтэйчүүдийн бүлгээс ИТХ-ийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн төлөөлөл болон шийдвэр гаргалтад саналаа тусган ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Төв аймгийн Өндөрширээт сумын алслагдсан бүсэд амьдардаг эмэгтэйчүүддээ холбогдох, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулахад хүндрэлтэй байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Сумын төлөөлөгч эмэгтэйчүүд нэгдэн, санаачилга гарган өрх толгойлсон эмэгтэйчүүд бидний амьдралд чин сэтгэлээсээ тусалж дэмжсэнд талархаж байна. Мөн эмэгтэйчүүдийн бүлэг байгуулагдсан нь бидний дуу хоолойг сум орны бодлого төлөвлөлтөд тусгах боломжтой болсонд баяртай байна.

Өндөрширээт сумын Сант багийн иргэн Г.Энхтуяа

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн хэмжээнд айл өрхийн судалгааг хийснээр бодит байдлыг таних, тухайн өрхүүдэд тулгамдаж буй асуудлуудаас шийдвэрлэх боломжтой болсон.

Эмэгтэйчүүд манлайлал, нийгмийн оролцоо, хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдсанаар тэдний мэдлэг, ур чадвар нэмэгдэхийн зэрэгцээ бусдадаа эергээр нөлөөлөх болсон

Эмэгтэйчүүдийн бүлэглэл орон нутгийн төлөөллийн байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оролцоо нэмэгдсэн

Орон нутгийн төлөөллийн байгууллага нь эмэгтэйчүүдтэй хамтран ажиллах хамтын ажиллагаа сайжирсан.

3. Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ МИНИ ПАРЛАМЕНТ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Т. ЭРДЭНЭБАТ, Баянхонгор аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга.
Холбоо барих утас: 95112459, 89995971
Цахим хаяг: Erdenebat.tumen@gmail.com
Хариуцан гүйцэтгэсэн: Ц.Байгальмаа, Баянхонгор аймгийн ИТХ-ын
ахлах мэргэжилтэн
Холбоо барих утас: 99445065

Цахим хаяг: Baigalia_83@yahoo.com

АГУУЛГА

Баянхонгор аймгийн хэмжээд ЕБС-ийн сурагчдыг хамруулсан “Мини парламент” байгуулан түүгээрээ дамжуулан хүүхдүүдийг шийдвэр гаргах түвшинд өөрсдийн санал бодлоо илэрхийлэх ур чадварт суралцуулан, нийгмийн идэвх оролцоог сайжруулсан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хувьсан өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгэмд хүүхэд бүр өөрсдийн гэсэн санал бодолтой хувь хүн болон төлөвшиж байгаа учраас хүүхдийн дуу хоолойг орон нутгийн бодлого шийдвэрт тусгах, тэдэнд тулгамдаж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар өөрсдийнх саналыг сонсох асуудал тулгамдаж байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Баянхонгор аймгийн ЕБС-ийн сурагчдыг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 03-р сарын 19-ны өдрөөс 2019 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл хэрэгжүүлсэн. Цаашид тогтмолжуулах зорилготой байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 33 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын дэргэд 20 сумын ерөнхий боловсролын сургууль болон аймгийн төвийн зарим ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг оролцуулан 33 сурагчдын бүрэлдэхүүнтэй “Мини парламент”-ийг байгуулсан. Аймгийн аймгийн ИТХ-ын дэргэдэх “Мини парламент” нь 2019 онд 2 удаа хуралдаж, дотоод зохион байгуулалтаа хийж, өөрсдийн тулгамдсан асуудал, санал хүсэлтийг илэрхийлж, орон нутгийн бодлого шийдвэрт тусгах боломжийг бий болсон.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 33 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын дэргэд 20 сумын ерөнхий боловсролын сургууль болон аймгийн төвийн

зарим ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг оролцуулан 33 сурагчдын бүрэлдэхүүнтэй "Мини парламент"-ийг байгуулсан.

- Аймгийн аймгийн ИТХ-ын дэргэдэх "Мини парламент"-ын төлөөлөгч-сурагчдын анхдугаар хуралдаанаа 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хийж, хуралдаанаар зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж, төлөөлөгч сурагчдын олонхын саналаар 11 Тэргүүлэгчтэй байхаар тогтож, олонхын саналаар Тэргүүлэгчдээ сонголоо. Мөн Тэргүүлэгчдээс "Мини парламент"-ийн даргаар Соого Сейко сургуулийн 10а ангийн сурагч Б.Туяацэцэг сонгогдсон.
- "Мини парламент"-ийн сурагчдыг чадавхжуулах, мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХТ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээс Монгол Улсын их сургуулийн Мини парламент клубтэй хамтарсан сургалтыг зохион байгуулсан.
- Тодорхой мэдлэг ойлголтыг авсан учраас хүүхдээр дамжуулан тэдэнд тулгамдаж байгаа асуудлыг судлах, санал хүсэлтийг шийдвэрлэх уулзалт, хуралдааныг тогтмол зохион байгуулж байна.



Баянхонгор аймгийн ИТХ-ын дэргэдэх "Мини парламент"-ийн ээлжит чуулганаар

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Аймгийн ИТХ-ын жил жилийн төсөвт тусган баталдаг "Хуралдааны зардал"-ыг нэмэгдүүлэх замаар "Мини парламент"-ын үйл ажиллагааны санхүүжилтийг шийдвэрлэж байна. Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр "Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төслийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нэг удаагийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Хүүхдүүд санал бодлоо орон нутгийн бодлого шийдвэрт тусгах боломж бий болж, тэдний оролцоо нэмэгдсэн
- Хүүхдүүдийн НӨУБ-ын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, эерэг хандлага бий болсон
- Нэгдсэн зохион байгуулалтад орж, саналаа нэгтгэх боловсруулах чадварыг эзэмшүүлсэн
- Цаашид жилд 2-оос доошгүй удаа хуралдаан зохион байгуулж, чөлөө цагт Тэргүүлэгчид тогтмол үйл ажиллагаа явуулна

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Тус ажлыг хийхэд тулгамдсан бэрхшээл байхгүй.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Би 2019 онд “Мини парламент”-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. “Мини парламент”-д орсноор би өөрийн санал хүсэлтээ орон нутгийн удирдлагуудад илэрхийлэх, дэвшүүлэхэд илүү найдвартай, боломжтой болж өгсөн бөгөөд хүүхдүүд бидний дуу хоолойг сайн сонсох гүүр нь болсон. Мөн “Мини парламент”-д орсноор надад илүү олон чадварууд бий болсон. Суралцах ч зүйл их байдаг. Жишээлбэл: 1. Хурлын дэг журам Бусдыг сонсох, хүлээцтэй, анхааралтай байх Илтгэх өөрийгөө илэрхийлэх чадвар гэх мэт. Улам илүү ихийг сурч мэдэж, “Мини Парламент”-аа улсын хэмжээний жишиг болсон туршлагаудыг бий болгож, хичээх болно.

Баянхонгор сумын Номгон сургуулийн 10 дугаар ангийн сурагч Б. Ариунзаяа

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн иргэд болон хүүхдүүдийн нийгмийн идэвх оролцоо, санал санаачилга сайжирсан.

Хүүхдүүд тэдэнд тулгамдаж буй асуудал болоод цаашид хийгдээсэй гэж хүсэж буй зүйлийнхээ талаар санал бодлоо бусдад хуваалцаж сурсан.

Хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө илэрхийлэх чадамж, бусдыг сонсох, хүндлэх, багаар ажиллах гэх мэт олон ур чадварт суралцсан.

Хүүхэд, эцэг эхчүүд, асран хамгаалагчдын архи, тамхины хор нөлөө, нийгэм дэх сөрөг үр дагаврын талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн.

Төрийн болон төлөөллийн байгууллага нь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд тэдний дуу хоолойг хүргэхэд ямар үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ шаардлагатай байгааг илүү сайн мэдэх боломж бүрдсэн.

Хавсралт 1. "Мини парламент" байгуулж ажиллах журмыг батлах тухай 33 дугаар тогтоол**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 33

Номгон

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын дэргэд "Мини парламент" байгуулж,
ажиллах журмыг батлах тухай

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2019 оныг "Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил" болгон зарласантай холбогдуулан тухайн жилд зохион байгуулах ажлын хүрээнд хүүхдийн зөв хүмүүжил, төлөвшлийг бий болгох, соёлтой мэтгэлцэх, мэтгэлцээний ур чадварыг хөгжүүлэх, мэдлэг туршлагаа нэмэгдүүлэх, хүүхдийн бие даасан бүтээлч сэтгэлгээ, чадавхийг хөгжүүлэх, хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудлыг өөрсдийнх нь оролцоотой шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд хүүхдийн өөрөө удирдах байгууллага болох "Мини парламент"-ийг байгуулсугай.
2. Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд "Мини парламент"-ийг байгуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөж, Засаг дарга нарт даалгасугай.
3. "Мини парламент"-ын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/th togtool-2019

Хавсралт 2. "Мини парламент"-ийн ажиллах журам

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний
өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт

**"МИНИ ПАРЛАМЕНТ"-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ****Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд ажиллах хүүхдийн өөрөө удирдах байгууллага болох "Мини парламент"-ийн үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөн ажиллана.

1.2. "Мини парламент"-ийн зорилго: Хүүхдийн зөв хүмүүжил, төлөвшлийг бий болгох, соёлтой мэтгэлцэх, мэтгэлцээний ур чадварыг хөгжүүлэх, мэдлэг туршлагаа нэмэгдүүлэх, хүүхдийн бие даасан бүтээлч сэтгэлгээ, чадавхийг хөгжүүлэх, хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудлыг өөрсдийнх нь оролцоотой шийдвэрлэхэд оршино.

1.3. "Мини парламент" нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, тэдгээртэй холбогдох бусад хууль, тогтоомжууд болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. "Мини парламнет"-ийн бүтэц, бүрэлдэхүүн

2.1. Сум тус бүрийн "Мини парламент"-ийн төлөөлөл нэг сурагч, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийг төлөөлсөн сурагчдаас бүрдсэн 25-30 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд ажиллана.

2.2. Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд тухайн сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас бүрдсэн "Мини парламент" ажиллана.

2.3. "Мини парламент"-ийн бүрэлдэхүүнд анги хамт олноо манлайлан, сурлагын амжилт гаргаж, цаашид бусаддаа үлгэр дуурайлал болохуйц, өөрийгөө зөвөөр илэрхийлэх чадвартай сурагчдыг сайн дурын үндсэн дээр оруулна.

2.4. "Мини парламент"-ийн даргыг гишүүдийн дотроос олонхийн саналаар сонгоно

Гурав. "Мини парламент"-ийн гишүүдийн эрх, үүрэг

3.1. Хүүхдүүдийн өмнө тулгарч буй асуудлыг дэвшүүлэн тавьж, шийдвэрлүүлэх

3.2. Монгол ёс уламжлалыг бусдад үлгэрлэн таниулж, зөв төлөвшлийг бий болгох

3.3. Байгаль орчноо хайрлан хамгаалах талаар үе тэнгийн хүүхэд, багачуудад мэдээ, мэдээлэл хүргэх

3.4. Бусад ямар төрлийн асуудлаар асуудал дэвшүүлж, санал гаргаж болно
Дөрөв. "Мини парламент"-ийн үйл ажиллагаа

3.1. "Мини парламент"-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2. Улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд ээлжит бус хурлыг гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно.

3.3. Хуралдаанаас зөвлөмж гаргах бөгөөд зөвлөмжийг гишүүдийн нэгдмэл саналыг үндэслэх зарчмыг баримтлана. Гишүүд нэгдмэл саналд хүрэхгүй тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй гишүүдийн саналаар шийдвэрлэнэ.

3.4. Зөвлөмж нь санал, дүгнэлт хэлбэртэй байж болно. Зөвлөмжид дарга, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Тав. Бусад зүйл

Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Зөвлөлийн гишүүдийн олонхийн санаачилгаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталгаажуулна.

4. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ХИЙЦТЭЙ ЦАЙ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Т.БЭРЦЭЦЭГ, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга. Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, УЗАШ Хорооны нарийн бичгийн даргын сонгуульт ажлыг хийдэг. 2009 оноос ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна. **Холбоо барих утас:** 86068184, **Цахим хаяг:** bertsetseg2016@gmail.com

АГУУЛГА

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг бүлэгт хуваарилан тогтсон өдөр, тогтсон цагт уулзалт хийн, энгийн байдлаар ярилцан, санал хүсэлтийг авч, асуудлыг шийдвэрлэх арга замыг бий болгосон.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Өмнөдэлгэр сумын хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, асуудлыг шийдвэрлэх, тэднийг нийгмийн харилцаанд татан оролцуулах асуудал орхигдож байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Өмнөдэлгэр сумын ИТХ-ын ажлын алба, эмэгтэй төлөөлөгчид, БИНХ-ын эмэгтэй дарга нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 2 сараас 2018 оны 11 сар хүртэл хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

ИТХ-ын ажлын алба, эмэгтэй төлөөлөгчдийн санаачилгаар “Хийцтэй цай” зорилтот ажлыг хэрэгжүүлэн 6 багийн 18 зорилтот бүлгийн өрх, иргэдийг хамруулан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж холбогдох хууль, тогтоомжийг танилцуулан, тэдний санал, хүсэлтийг хүлээн авсан. Тухайн бүлгийн иргэдтэй хэт олноор бус 5-8 хүнтэй уулзалтыг цай ууж, хоол идэнгээ энгийн хөгжилтэй байдлаар ярилцлагыг хийж хэнд ямар асуудал тулгамдаж байгааг ярилцлагын дундаас олж авсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд ДЗОУБ-тай хамтран “Төгсөлтийн аргачлал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн өрхийг хамруулан ажлын байраар хангасан,
- ЕБС-ын дэргэдэх албан бус боловсрол, ДЗОУБ-тай хамтран “Туузан урлал”, “Торт хийх аргачлал”, “Арьс арчилгаа”, “Дээл эсгэх, оёх” Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулалт”, “Хүнсний ногоо тариалалт” зэрэг чадавхжуулах сургалтуудыг явуулж нийт давхардсан тоогоор 25 иргэнийг хамруулсан,

- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг болон архины хамаарлаас хэрхэн ангижрах талаар залуу болон дунд насны гэр бүлд зориулан 5 удаагийн лекцийг уншуулж, архины хамааралтай 2 иргэнд сэтгэл зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн,
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр “Хүчирхийллийн эсрэг эмэгтэйчүүдийн дуу хоолой” сургалт, өдөрлөгийг зорилтот бүлгийн 80 эмэгтэйчүүдийг хамруулан зохион байгуулж “Гэр бүлийн баяр хөөр” лекцийг АШУУИС-ийн НАСС эмч, Япон улсын Надешико шүдний эмнэлгийн эмч нар зохион байгуулж бүрэлдэхүүнийг урьж зорилтот өрхийн амны хөндийг эрүүлжүүлэх үзлэг, эмчилгээнд хамруулсан,
- Засаг дарга, газрын даамалд хүсэлт тавьж сумын төвөөс зайдуу амьдардаг 6-р багийн хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон 5 хүүхэдтэй эмэгтэй Д-д сумын төвд өөрийн гэсэн газар олгон, ЕБС, “Модон цаг” ХХК-тай хамтран хашааг нь барьж өгсөн. Мөн хүүхдүүдийг нь цэцэрлэгт хамруулан сургуулийн хүүхдүүдэд нь хичээлийн хэрэгслэл, хувцас өгсөн. Тэдний гэрээр байнга айлчлан эерэг хандлагыг бий болгосон,
- Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, эрүүл энх урт удаан наслах, оюуны өвчлөлөөс хамгаалах бүхий л боломжийг чухалчлан хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд харьяалалгүй ахмадыг харьяалах байгууллагатай болгох, сар бүр багууд “Нас тогтох сайхан” Ахмадын нэрэмжит өдөрлөг зохион байгуулж нийтдээ 25 ахмад настны алдрыг тэмдэглэн 12 ахмад настныг салбарын шагналаар шагналаа. БИНХ, Хурлын Төлөөлөгчид, Багийн Засаг дарга нар хамтран нийтдээ 1200.0 мянган төгрөгөөр ивээн тэтгэсэн,
- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчидтэй хамтран 30 ахмадад нийт 6.0 сая төгрөгийн эрхийн бичиг олгуулж, Улаанбаатар хотын “Сонгино” амралт, сувилалд үнэ төлбөргүй сувилуулсан,
- Дэлхийн гэр бүлийн өдрөөр Олны талархлыг хүлээсэн ногоон хөгжлийг дэмжигч шилдэг гэр бүлийг шалгаруулсан,
- “Хүмүүнлэгийн дуулал” урлагийн тоглолтыг гэр бүл, анги хамт олноор нь 2 удаа зохион байгуулж орсон орлогыг эмчилгээний зардал шаардлагатай 2 иргэнд олгосон,
- 100 хувийн харааны бэрхшээлтэй Э-д бариа засал хийх ажлын байр шаардлагатай байгаа хүсэлтийг хүлээн авч ЭМТ-д хандан ажлын байраар хангасан.



Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын “Хийцтэй цай” зорилтот ажлын үйл явц

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Сумын нийт иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулан аян өрнүүлэн санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Энэхүү зорилтот ажлыг хэрэгжүүлэхэд нөлөөллийн ажлууд хийх цаг хугацаа болон мэргэжлийн чадвар дутмаг байсан хэдий ч ИТХ-ын төлөөлөгчид айл өрхийн амьжиргааны түвшнийг мэддэг болсон ба зорилтот бүлгийн өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, иргэд руу чиглэсэн ажлуудыг эрэмбэ дараатайгаар хийдэг болсон.
- Иргэд ИТХ-ын төлөөлөгчдөдөө хандаж санал, хүсэлтээ гаргаж асуудлаа шийдүүлдэг болсон төдийгүй Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан.
- Хурлын Төлөөлөгчид, БИНХ-ыг дарга нарын чадвар дээшилсэн.
- Иргэд олон нийтийн ИТХ-ын хандах хандлага нэмэгдсэн зэрэг үр дүн, ололт амжилттай онцлох ажил болсон.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Амьдралын нөхцөл боломж тааруу өрхийг сонгон авч гэр олгон амьдрах орчныг хангаж өгсөн хэдий ч цаашидаа тухайн гэр бүл яаж энэ амьдралыг авч явах, цаашид хүүхдийнхээ боловсрол, гэр бүлийн харилцаа, санхүүгийн асуудлаа хэрхэн, яаж шийдвэрлэх вэ гэх зэргээр асуудал үүсэж байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

баяртай байна.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын иргэн н.Өнөржаргал

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн хэмжээнд айл өрхийн судалгааг хийснээр бодит байдлыг таних, тухайн өрхүүдэд тулгамдаж буй асуудлуудаас шийдвэрлэх боломжтой болсон.

Эмэгтэйчүүд хамтран орон нутагт олон чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулсан нь бусад эмэгтэйчүүдийн асуудлыг шийдэхийн зэрэгцээ хөгжих, ажлын байртай болох боломжийг олгосон.

Эмэгтэйчүүдийн бүлэглэл орон нутгийн төлөөллийн байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оролцоо нэмэгдсэн.

Нийгмийн асуудалд эмэгтэйчүүдийг татан оролцуулах нь үр өгөөж болохыг илүү сайн таньж мэдсэн.

Хавсралт 1. Өмнөдэлгэр сумын эмэгтэй төлөөлөгчдөө зохион байгуулж буй “Хийцтэй цай” зорилтот ажлын удирдамж



-Дэмжлэг, тусламж зайлшгүй шаардлагатай иргэн, айл өрхийг сонгоход өөрийн ах дүү, хамаатан садан, танил найз нөхдийг сонгохгүй байж ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах

-Уг ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, санхүүжилтийг хандив, тусламжаар босгох ажлыг ажил хариуцагч нар өөрсдөө зохион байгуулна.

ИТХУРЛЫН АЖЛЫН АЛБА, ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧИД, БИНХ-ЫН ДАРГА
НАР

5. Ховд аймгийн Дөргөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Н.БАЗАРРАГЧАА, Ховд аймгийн Дөргөн сумын ИТХ-ын дарга.

Дээд боловсролтой, 2014 онд Ховд аймгийн Дөргөн сумын ЗДТГ-ын төрийн санч, 2016 онд сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон одоог хүртэл ажиллаж байна.

Холбоо барих утас: 88103902

Цахим хаяг: Bazaraa_22@yahoo.com

АГУУЛГА

Ховд аймгийн Дөргөн сумын хэмжээнд “Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр” батлан, хэрэгжүүлснээр зорилтот орон нутгийн залуучуудыг дэмжих нэгэн хөшүүрэг болсон.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Залуучуудад хандсан аливаа үйл ажиллагаа явуулахад санхүүгийн хүндрэл байнга тулгарч сумын Залуучуудын холбоо зохион байгуулах үйл ажиллагааныхаа санхүүжилтийг бусдаас хайдаг байсан. Харин залуучуудад чиглэсэн хөтөлбөр батлуулснаар сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын жагсаалд оруулан, санхүүжилтийг шийдэх боломжтой болсон.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Дөргөн суманд амьдардаг 18-40 насны залуусыг хөтөлбөрийн хүрээнд хамруулан үйл ажиллагаанд оролцуулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018, 2019, 2020 оны 4 сард зохион байгуулсан.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Сумын Залуучуудын холбоо, ИТХ-ын тэргүүлэгчидтэй харилцан хамтран ажилласан. Үйл ажиллагаанд залуучуудыг баг бүрээс тэгш оролцуулах /Малчин, ажилгүй, төрийн болон бус байгууллагад ажилладаг зэргээр нь/ зарчмыг баримталсан. Залуучуудад зөв хандлага, харилцааг төлөвшүүлэхэд мэргэжлийн хүмүүс болон салбартаа манлайлан ажиллаж байгаа залуучуудаар тэргүүлүүлэхийг зорьсон.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөрийг боловсруулсан,
- Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөрийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулсан,
- Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөрийг иргэдэд сурталчилсан,
- Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөрийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын жагсаалд оруулан сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулсан,
- Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 5 сая төгрөг батлуулан “Залуучуудын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан. Баг бүрийн идэвхтэн залуучууд үйл ажиллагаанд хувиасаа хөрөнгө оруулалт /бэлэн мөнгө, хонь, бичиг хэрэг/ хийсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Сумын Залуучуудын холбооны үйл ажиллагаа тогтвортой явагддаг болсон.
- Залуучуудын нийгмийн идэвх оролцоо өмнөх үетэй харьцуулахад илүү сайжирсан.
- “Дөргөн ногоон хөгжил үндэсний нийгэмлэг”-ийн санаачилсан 500 ширхэг мод тариалалтыг хийхэд Залуучууд сумын иргэдийг уриалан амжилттай зохион байгуулсан.
- Залуучууд морин аялалд оролцон, орон нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт газруудыг танин мэдэж, байгаль хамгаалах талаар санал санаачилгаа гаргасан
- Урлаг, спортын амжилт гаргаж, харилцаа, хандлагаа өөрчлөх сургалт, үйл ажиллагаанд оролцож, сэтгэл зүйн хандлагаа эергээр өөрчлөхөд нөлөөлсөн
- Орон нутгийн иргэд, залуучууд болон төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирсан.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Залуучуудад нийгэм, сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлж, хөгжлийг дэмжих зорилгоор /тогтсон хандлагыг өөрчлөх, бэлэнчлэх сэтгэлгээ, цаг баримтлахгүй байх, нийгмийн идэвхгүй байх гэх мэт/ суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажилладаг боловч мэргэжилтэн дутмаг байдаг. Тухайлбал залуу гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч дутмаг. Хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажил бүрийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдэх боломжгүй байдаг.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Сумын ИТХ-ын болон Гэргүүлэгчийн хуралдаанаар баталсан хөтөлбөрүүдийг иргэд, олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нь чухал. Ингэж чадвал иргэд тухайн хөтөлбөрийг дэмжиж санал өгснөөр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажлын жагсаалд оруулах боломж бүрддэг.

Ховд аймгийн Дөргөн сумын иргэний сэтгэгдлээс...

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Сумын залуучуудын холбооны үйл ажиллагаа тогтворжиж, тодорхой асуудал, шийдэл рүү чиглэх болсон.

Залуучуудын төлөөллөөр дамжуулан орон нутгийн иргэдийг идэвхжүүлэх, хамтын ажиллагааг илүү сайжруулсан.

ОНХС-ийн хөрөнгөөр хийж ажилд залуучуудыг дэмжих хөтөлбөрийг оруулан, төсөв санхүү, үйл ажиллагааг нарийвчилснаар залуучуудын хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн оролцоог хангахад анхаарсан.

Хавсралт 1. Хөтөлбөр батлах тухай 13 дугаар тогтоол

ХОВД АЙМАГ
ДӨРГОН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 13

Сээр

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 20.1.14, Залуучуудын хөгжлийг хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын "Залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Н.Базаррагчаа/, Засаг дарга /Т.Заяа/ нарт үүрэг болгосугай.



ДАРГА /Н.БАЗАРРАГЧАА

Хавсралт 2. Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр**“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ”
ДЭД ХӨТӨЛБӨР****НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

Дөргөн сум 3044 хүн амтайгаас 15-34 насны 1129 өсвөр үе, залуучууд хүн амын 37 хувийг эзэлж байна. Залуучуудын өмнө тулгарч буй нийтлэг асуудал, эрх ашгийг тодорхойлон түүнийг шийдвэрлэх зөв арга замыг олж, залуучуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэн залуу гэр бүлийн суурь хэрэгцээг хангахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр гарааны бизнесийг дэмжих, бага хүүтэй зээл, санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлэх, өөрөө өөртөө ажлын байр бий болгон бизнесээ өргөжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд хэрэгтэй байна.

Суманд залуучуудын амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх орчин нөхцөл бүрдээгүй байгаа нь залуучууд сумандаа амьдрах хүсэл сонирхол багасаж, шилжин явах нь ихсэх хандлагатай байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Орон нутгийн залуучуудын өмнө тулгарч буй нийтлэг асуудал, давуу тал, нөөц боломжийг нь тодорхойлон залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх нөхцөл, эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилтот арга хэмжээнүүдийг зохион байгуулахад оршино.

**ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН**

3.1. Хамрах хүрээ: 15-39 насны залуучуудыг хамруулна.

3.2. Зорилт, үйл ажиллагааны чиглэл

Зорилт 1. Залуучуудын утга учиртай оролцоог нэмэгдүүлэх

Зорилт 2. Залуучуудын эрүүл мэндийг дэмжих

Зорилт 3. Залуучуудын боловсрол, хөгжлийг дэмжих

Зорилт 4. Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн залуучуудын сонирхол давуу талд нь тулгуурлан нийгмийн олон талт дэмжлэг үзүүлэх

Зорилт 5. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, ажилтай, орлоготой амьдрах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх.

3.1	Хөдөөгийн багуудаар насан туршийн боловсролын багшийг ажиллуулах замаар залуучуудыг суурь боловсролтой болгох	2018-2020	Залуучуудын холбоо	Насан туршийн багш	1000000	Засаг дарга
3.2	Залуучуудын гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдал, эерэг харилцаа, хандлагын талаар сургалт	2018-2020	Залуучуудын холбоо			Залуучуудын холбоо
3.3	Номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох арга хэмжээ авах	2018-2020	Залуучуудын холбоо	Сумын номын сан		Залуучуудын холбоо
3.4	Залуучуудыг соёл урлаг, шинэжлэх ухааны бүтээл туурвихад нь дэмжлэг үзүүлэх	2018-2020	Залуучуудын холбоо		2000000	Орон нутгийн хөгжлийн сан
3.5	Залуучуудын дунд соёл урлаг, спортын тэмцээнүүдийг зохион байгуулах	2018-2020	Залуучуудын холбоо		1500000	Засаг дарга, төсөл хөтөлбөр
3.6	"Сумын хөгжил ба залуучууд" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах	2018-2020	Залуучуудын холбоо	Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар	300000	Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар
3.7	Үйл ажиллагааны чиглэлд хамрах санхүүжилт				4800000	
4.Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн залуучуудын сонирхол давуу талд нь тулгуурлан нийгмийн олон талт дэмжлэг үзүүлэх						
4.1	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн залуучуудын сонирхол, хэрэгцээ, давуу талд сууриалсан үйлчилгээнд холбон зуучлах, бие даасан байдлыг нь дэмжих	2018-2020	Залуучуудын холбоо	ХБИ-ийн төрийн бус байгууллага	300000	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, орон нутгийн хөгжлийн сан
4.2	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, чиглэлээр олон нийтэд түшиглэн, сайн дурын оролцоотойгоор зохион байгуулах.	2018-2020	Залуучуудын холбоо	ХБИ-ийн төрийн бус байгууллага	100000	Төрийн бус байгууллага
4.3	Үйл ажиллагааны чиглэлд хамрах санхүүжилт				400000	
5.Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, ажилтай, орлоготой амьдрах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх.						
5.1	Залуучуудыг хувиараа, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих	2018-2020	Залуучуудын холбоо	Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн	10000000	Сум хөгжүүлэх сан
5.2	Залуу малчдыг малжуулах хөтөлбөрт хамруулах.	2018-2020	Залуучуудын холбоо	Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн	6000000	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
5.3	Мэргэжлийн ур чадвараа сайжруулах.	2018-2020	Залуучуудын холбоо	Хөдөлмөр, халамж	1000000	Хөдөлмөр, халамж

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагдах төсөв /сая/ төгрөгөөр	
			Хариуцагч	Хамтрагч	Төг	Эх үүсвэр
Зорилт 1. Залуучуудын утга учиртай оролцоог нэмэгдүүлэх						
1.1	Залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах	2018-2020	Залчуучуудын холбоо	ИТХ-ын дэргэдэх залуучуудын зөвлөл	1500000	ОНХС, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, залуучуудын оролцоо
1.2	"Залуучуудын танхим" байгуулж, тохижуулж янзлах	2018-2020	Залчуучуудын холбоо	15-34 насны залуучууд	3000000	ОНХС, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, залуучуудын оролцоо
1.3	"Чадварлаг залуу төрийн албан хаагч"-ын нэгдсэн зөвлөгөөн өдөрлөг зохион байгуулах	2019	Залчуучуудын холбоо	Залуу төрийн албан хаагчид	1500000	Төсөл хөтөлбөр
1.4	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах	2018-2020	ИТХ-ын дэргэдэх залуучуудын зөвлөл	Залчуучуудын холбоо, ИТХ	1500000	ИТХ, ОНХС
1.5	Залуучуудын "Шинэ жил"-ийг 2 жилд нэг удаа зохион байгуулах	2018-2020	Залчуучуудын холбоо	ИТХ-ын дэргэдэх залуучуудын зөвлөл, Нийт залуучууд	1500000	Залуучуудын холбоо
1.6	Амжилт бүтээлээрээ бусдыгаа манлайлаж, хошуучилсан, тэргүүний залуучуудыг шагнаж урамшуулах	2018-2020	Залуучуудын холбоо	Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар	500000	Засаг дарга
1.7	"Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах" өдөрлөг зохион байгуулах /мод тарих, хог цэвэрлэх гэх мэт/	2018-2020	Залуучуудын холбоо	Нийт залуучууд	300000	Залуучуудын холбоо
1.8	Үйл ажиллагааны чиглэлд хамрах санхүүжилт				9800000	
2.Залуучуудын эрүүл мэндийг дэмжих.						
2.1	Залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт зохион байгуулах	2018-2019	Залчуучуудын холбоо	Эрүүл мэндийн төв Залуучуудын холбоо	500000	Эрүүл мэндийн төв
2.2	"Архи тамхи шинэ үеийн сонголт биш" нөлөөллийн арга хэмжээ, сургалтыг зохион байгуулах	2018-2020	Залчуучуудын холбоо	Эрүүл мэндийн төв	500000	Эрүүл мэндийн төв
2.3	"Өглөөний мэнд" залуучуудын бүлгэм байгуулж, дулааны улиралд өглөө эрт дасгал хөдөлгөөн, гүйлт тогтмол хийж байх.	2018-2020	Залчуучуудын холбоо	Нийт залуучууд	200000	Залуучуудын холбоо
2.4	Үйл ажиллагааны чиглэлд хамрах санхүүжилт				1200000	
3.Залуучуудын боловсрол, хөгжлийг дэмжих						



1. Увс аймгийн Зүүнговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Ж.БАЯНТӨР, Увс аймгийн Зүүнговь сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга. Төрийн захиргааны удирдлагаар мэргэшсэн. 1996-2004 онд ЗДТГ-ын нярав, 2004 оноос Зүүнговь сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 95777575,

Цахим хаяг: bayanturjutaan@gmail.com

АГУУЛГА

Увс аймгийн Зүүнговь сумын бэлчээр ашиглалтыг сайжруулах, бэлчээр ашиглалтад дагаж мөрдөх хууль зүйн баримт бичигтэй болох, түүнийг дагаж мөрдөх ажлууд хийгдсэн байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Увс аймгийн Зүүнговь сумын малчин өрхүүдэд бэлчээр ашиглахдаа орон нутгийн эрх зүйн зохицуулалтын актгүйгээс, дуртай нутгаа сэлгэн буудаг байна. Энэ нь бэлчээрийг зохисгүй ашиглах, бусад малчин өрхөд хүндрэл учруулахад хүргэж байна.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Увс аймгийн Зүүнговь сумын малчин иргэд

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017 оны 07 дугаар сараас 2018 оны 04 дүгээр сарын 01 хүртэл журам боловсруулах батлах үйл явц хийгдсэн ба одоо дагаж мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

- “Бэлчээр ашиглах журам” боловсруулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хууль зүйн яаманд бүрдгүүлэн дагаж мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Сумын газар нутгийн ашиглагдахгүй байгаа газар нутгийг хуваариар ашиглах талаар малчдад ухуулга сурталчилгаа хийх,
- Багийн ИНХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргаж мөрдүүлэх,
- Журмыг хэрэгжилтийг зөрчиж байгаа малчдад хууль журмын хүрээнд арга хэмжээ авах,
- Зэргэлдээ сумын малчид орж нутаглаж байгааг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах /ЗДТГ-ын байцаагч нар газар дээр нь ажиллаж нүүх талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, нүүхгүй бол зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авах/,
- Малаа байнгын хариулга маллагаатай байлгах зэрэг арга хэмжээг авч байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Сумын нийт малчдыг 8 бүлэгт хуваан хэсэг тус бүр дээр 2 удаа нийтийн сонсгол зохион байгуулан санал бодлыг авч журмын төсөлдөө тусган ИТХ-ын хуралдаанаар баталсан. 2018, 2019 онуудад хэрэгжилтийг хангахаар ажлын төлөвлөгөөнд тусган ажилласны үр дүнд ахиц дэвшил гарч байгаа болно. Журмыг сумын нийт өрхийн тоогоор хэвлэн олшруулж бүх өрхүүдэд хүргүүлсэн.

- Журмыг баталж гаргахдаа малчдын 8 бүлэгт нийтийн сонсгол зохион байгуулсан ба ИТХ-ын төлөөлөгч нар сонгогдсон тойрогтоо ажиллан журмын талаар танилцуулга хийж иргэдийн санал сонсох ажлыг зохион байгуулсан.
- Бэлчээр ашиглалтын талаар судалгаа хийх ажлыг сумын байгаль орчны хэсэг, бэлчээр ашиглагчдын холбоо, төслийн багтай хамтран 8-р дугаар сарын 20-ны өдрөөс 28-ны өдрүүдэд сумын нутаг дэвсгэрт фото мониторингийн судалгаа хийн дүнг нэгтгэн гаргасан.
- Өвөлжөө хаваржаа, намаржааны судалгаа гаргах ажлыг сумын бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-тай хамтран газрын зураг дээр тэмдэгжүүлэн тэмдэг тэмдэглэгээ хийлээ.
- Бэлчээр ашиглах талаар сумын нутаг дэвсгэрийн хэмжээний газрын зураг хэвлүүлсэн ба бэлчээр ашиглалтын хэсэг бүр дээр газрын хэмжээг тогтоосон зураг гаргасан.
- Ажлын төлөвлөгөө гарган ажилласан.
- Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг сумын засаг даргын 2016–2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг Сумын засаг даргын 2019 оны зорилтын холбогдох заалтууд, Байгаль орчны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн шийдвэрийг биелүүлэхийн төлөө ажлын чиглэл бодлогоо уялдуулан ажиллаж байна.
- Байгаль орчны бодлого, сумын засаг даргын нийгэм эдийн засгийн төлөвлөгөөнд туссан заалтыг тусган байгаль хамгаалагчийн үйл ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, байгаль орчин тогтвортой хөгжлийн тасгийн 2019 оны ажлын төлөвлөгөө зэргийг боловсруулж аймгийн байгаль орчны дарга, сумын засаг даргаар баталгаажуулан ажиллаж байна.
- Сумын бэлчээр ашиглах журам гарсантай холбогдуулан ИТХ-ын тогтоол, шийдвэрийг иргэдэд сурталчлах зорилгоор багуудын өдөрлөг, 14 хоногийн мэдээллийн цаг болон айл өрхүүдээр явж давхардсан тоогоор 418 орчим иргэнд сурталчлав. Мөн ЗДТГ-ын нээлттэй хаалганы өдрөөр айл өрхүүдээр явж иргэдийн санал хүсэлт сонсож, хууль эрх зүйн зөвлөмж өглөө.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

- Бэлчээр ашиглах журмыг батлан гаргахдаа “Монгол улсад төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөлд “Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нийтийн сонсгол зохион байгуулах нь” төсөл шалгарч 4 сая төгрөгийн санхүүжилт авч төслийг хэрэгжүүлсэн.
- Журам батлагдан гарч хууль зүйн яаманд хянагдан хууль эрх зүйн санд бүрдгэгдсэнээс хойш жил сумын төсвийн давсан орлогоос 1-ээс 2 сая төгрөг суулган хэрэгжилтийг хангуулахаар сумын Засаг даргын жил бүрийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зорилт болгон оруулан ажиллаж байна.
- 2018 онд хэрэгжилтийг хангах эхний жил 2 сая төгрөг давсан орлогоос сумын төсөвт суулгаж айл өрхүүдэд сурталчилгаа хийх, хөрш зэргэлдээ сумдын малчдын нүүлгэх, бэлчээр чөлөөлөх гэх мэт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд зарцуулсан байн

Увс аймгийн Зундгай сумын "Бэлчээр ашиглалт"-ын зураг

1:250,000

- Сумын нийт газар нутгийн ашиглагдахгүй байгаа газар нутгийг бэлчээрийн зориулалтаар ашиглах, зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржаанд буух хугацааг тогтоосон ба багийн ИНХ-аараа хэлэлцэн асуудлуудыг шийдвэрлэж байхаар тогтсоны үр дүнд газрын маргаан багасаж ашиглагдахгүй байсан зах хязгаар нутгийг эзэмших явдал сайжирч буурь бууцны маргаан багассан байна.
- Журам захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 3888 дугаарт бүрдгэгдсэн болно. Зүүнговь сумын нутаг Тарвагатайн худаг, зүүн хөдөө , хойд худаг, дунд худаг зэрэг нутгуудаар Зүүнговь сумын бэлчээр ашиглах журам зөрчсөн Тэс сумын болон, Зүүнговь сумын 11 малчдыг тус бүрийг Зөрчлийн тухай хуулийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн 100000 төгрөгөөр торгож прокурорт хянуулахаар явуулсан байна.
- Хяналт шалгалтаар 2019 оны 4 сарын 24-ээс 7 сарын 02-ны хооронд нийт 8 удаа явахад бэлчээр ашиглах журам зөрчин Зүүнговь сумын 2, 3-р багийн нутаг дэвсгэрээр орж ирсэн Тэс сумын малчин айл өрхүүд болон журам зөрчиж байгаа Зүүнговь сумын малчдад хугацаатай албан мэдэгдэл өгч журмын хэрэгжилтийг хангаж ажиллахын сануулж шаардлага тавьж ажиллалаа. Нийт 8 удаагийн хяналт шалгалтаар 18 зөрчил илэрсэн ба үүнээс 4 айлд торгууль тавигдаж 14 айлд хугацаат албан мэдэгдэл өгч 14 айл албан мэдэгдлийн хугацаанд зөрчлөө арилгаж нүүж бэлчээрийг чөлөөлсөн байна.
- Өгөөмөр багийн нутаг зүүн хөдөөд хаваржихгүй нутгийн гүн рүү орж буудаг байсан нутагт 2018 онд иргэн Л.Чимэд-очир тэргүүтэй 4 нь айл эхний жил орж хаваржсан бол 2019 онд 16 айл орж хаваржин зах хязгаар нутгаа ашиглан амьдрах журмын хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

- Малчид зах хязгаар нутаг руу нүүж очиж бэлчээр ашиглах асуудал дээр хойрго хүндрэл үүсгэж нүүж өгөхгүй байх.
- Хөрш зэргэлдээ сумын малчдыг нүүлгэх талаар арга хэмжээ авах.
- Хэсэг бүлгээрээ хамтарч нүүж орохгүй бол малын хүлгай гарах эрсдэлтэй



ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Бэлчээр ашиглах журам гаргаж мөрдүүлснээр хаваржаа, зуслан, намаржих газрыг багийн ИНХ-аар хэлэлцэн шийдвэрлэж малчид өөрсдийн гаргасан шийдвэрээ дагаж мөрдөх зэрэг ололттой сайн талууд их байна. Цаашид хэрэгжилтийг хангах талаар байнга санал санаачилга гарган ажиллаж байвал малчид бидний амьдралд нэн тустай ажил болж байна.

Зүүнговь сумын Өгөөмөр багийн Засаг дарга С.Тогтохбаяр

Бэлчээр ашиглалтын журмын хүрээнд малчид ашиглахгүй байсан зах хязгаар нутгаа эзэмших санал санаачилга гарган эхний жил 4 малчин хязгаар нутгаар хаваржиж, намаржиж байсан бол 2 дахь жилээс 20 гаруй өрх болон жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Энэ нь өвөлжөөний буйр бууцаа хамгаалах сайн ажил болж байгаад малчид бид талархаж байна.

Зүүнговь сумын иргэн Л.Чимэд-Очир

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутгийн малчин иргэд “Бэлчээр ашиглах журам”-ын дагуу бэлчээр, нутгаа зөв зохистой ашиглах болсон.

Малчин өрхүүдэд малын бэлчээр нутгийн хуваарилалтын үл ойлголцлоос шалтгаалан маргаан үүсэх шаардлагагүй болсон.

Бэлчээр ашиглалттай холбоотой бүх асуудал хууль дүрмийн дагуу явагдсанаар орон нутагт жишиг дэг тогтсон

Нутгийн иргэд бэлчээрийн эрүүл ахуй, зөв ашиглалт зэрэг бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг сайжирсан.

Хавсралт 1. Бэлчээр ашиглах журам батлах 07/01 дугаар тогтоол

38



**УВС АЙМАГ
ЗҮҮНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн байд
2018. оны 04. сарын 17-ны
өдрийн 3188 дугаар тогтоол.

2018 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 07/01

Зөлийн гол

Журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дах хэсэгт заасныг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Хавсралт 2.Бэлчээр ашиглах журам хэрэгжүүлэх тухай А/36 дугаар захирамж**УВС АЙМГИЙН
ЗҮҮНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 4/36

Зэлийн гол

Журам хэрэгжүүлэх тухай

Монгол улсын газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, 52.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05/01 тоот тогтоолоор батлагдсан Зүүнговь сумын бэлчээр ашиглах журмыг хэрэгжүүлэх, тодорхой газар нутгийн онцлог, байгаль цаг уурын өөрчлөлтөөс гарч буй сөрөг үр дагаврыг багасгах, цөлжилтөөс хамгаалах, нөхөн сэргээх, ашиглагдахгүй байгаа газар нутгийг ашиглах, малчдын өвөлжөөний бүс нутгийг хамгаалах зорилгоор нэр бүхий газар нутгийг малын хөлөөс чөлөөлсүгэй.

2. Чөлөөлөх газрын нэр, чиглэл, байршил, хугацааг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /Б.Хүрэлхүү/, газрын даамал /Д.Эрдэнэ/, Тохой багийн Засаг дарга /Х.Золбат/, Өгөөмер багийн Засаг дарга /С.Тогтохбаяр/, Суварга багийн Засаг дарга /С.Батбаяр/, Баяннуур багийн Засаг дарга /С.Батмөнх/, Зэл багийн Засаг дарга /Ц.Баяраа/-нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.НЭРГҮЙ



55-0071

Хавсралт 3. Бэлчээр зөв, ашиглах тухай 04 дүгээр тогтоол**УВС АЙМАГ ЗҮҮНГОВЬ
СУМЫН ӨГӨӨМӨР БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 04/

Зэлийн гол

Г Бэлчээр зөв, зохистой ашиглах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9 дэх заалтыг үндэслэн багийн иргэдийн нийтийн хурлаас ТОГТООХ нь:

1. Тус багийн нутагт бэлчээрийг зөв зохистой ашиглах үүднээс Нуурын эхнээс Тоочигын орой хүртэл 05-р сарын 25-наас 08-р сарын 25-н хүртэл бог малтай айл өрх зусахгүй байх талаар багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг дэмжсүгэй.

2. Тухайн шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг багийн Засаг дарга /С.Тогтохбаяр/-т үүрэг болгосугай.



ДАРГА /С.Тогтохбаяр/ Г.УНСМАА

2. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал**“ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД МАЛЧДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ”**

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Ц.БЯМБАДОРЖ, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга. Соёлын арга зүйч, төрийн захиргаа удирдлага, нутгийн удирдлагын менежер, хууль зүйн ухааны магистраар мэргэшсэн. 2004 оноос Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ажиллаж эхэлсэн. 16 дахь жилдээ ажиллаж байна.

Холбоо барих утас: 89130497

Цахим хаяг: Byambaa_ith@yahoo.com

АГУУЛГА

Шийдвэр гаргах түвшинд малчдын оролцоог хангаж ажилласнаар орон нутгийн бэлчээр ашиглалт, төлөвлөлтийг зохистой болгох ажлыг санаачилсан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Орон нутгийн иргэдээс авсан санал, асуулгаар судалгаанд хамрагдсан малчдын 70 орчим хувь нь сум орон нутагт нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай, тулгамдаж буй асуудлыг бэлчээрийн ашиглалтын төлөвлөлтийг оновчтой болгох гэж санал дэвшүүлсэн. Сүүлийн жилүүдэд бэлчээрийн даац 5-6 дахин хэтрэлттэй байгаа нь орон нутгийн ХАА-н хөгжлийн бодлогод тулгамдсан, шийдвэрлэх гол асуудал болсон. Бэлчээрийн мал аж ахуй нь Монголын 160,000 гаруй малчин өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр бөгөөд хүнсний аюулгүй байдал, хөдөөгийн ажил эрхлэлтийн үндэс, улс орны соёл, өв уламжлалын салшгүй бүрэлдэхүүн хэсэг хэвээр байх болно. Малчдын хувьд бэлчээрийн даац хэтрэх, усгүй болох, маргаан, зөрчил ихсэж, төрийн зохицуулалт сул байгаагаас шалтгаалан дур зоргоор ашигладаг гэсэн асуудлуудыг бэлчээр ашиглалтын хүрээн дэх хамгийн тулгамдсан хурц асуудал гэж үзэж байна.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Малчин өрхүүдийг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оны 05 дугаар сараас эхлэн 2020 оны 03 дугаар сар хүртэл тасралтгүй хэрэгжиж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Шийдвэр гаргах түвшинд малчдын оролцоог хангах нь санал санаачилгыг өрнүүлж “Орон нутгийн бэлчээр ашиглалт, төлөвлөлтийг малчдын өөрсдийн оролцоотойгоор зохион байгуулах” нь ажлыг хэрэгжүүлсэн. Дундын бэлчээрээ хамтран ашигладаг нэг нутаг усны малчид бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулан хамтран ажиллана.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Жишиг багаар сонгон авсан багийн малчин өрхүүдэд танилцуулгын 2 төрлийн 400 ширхэг гарын авлага бэлтгэн 200 гаруй өрхүүдэд тарааж мэдээллээр хангасан.
- Малчдаас санал асуулгын судалгаа авч, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтийг малчдын оролцоотойгоор боловсруулсан.

- 110 гаруй малчин өрхийн төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг авсан.
- Малчдаас гарсан саналд үндэслэн хөдөөгийн 2 багт ИНХ-ын хуралдаанаар нь 85 гишүүдтэй 17 бэлчээр ашиглалтын ажлын хэсгүүдийг байгуулсан. Нэмж хөдөөгийн 2 багт байгуулахаар төлөвлөгдсөн байгаа.
- Бэлчээр ашиглалтын ажлын хэсгийн ахлагч нарт сургалт зохион байгуулсан.
- БААХ-ийн гишүүдэд бэлчээр төлөвлөлттэй холбогдох гарын авлагын цүнх аялуулан судлуулж байна.
- Бэлчээр төлөвлөлт, ашиглалтыг “Бэлчээр ашиглалтын ажлын хэсгийн санал”-д үндэслэн багийн ИНХ-ын хуралдаанаас саналыг баталж, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны шийдвэрийг үндэслэн зохин байгуулалтыг хийх ажлыг хэрэгжүүлж байна.



Хөвсгөл Аймгийн Төмөрбулаг сумын “Бэлчээр ашиглалт ийн төлөвлөлтийг сайжруулах” үйл явц

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Швейцарын Хөгжлийн Агентлагийн Ногоон алт, Малын эрүүл мэнд төслийг хэрэгжүүлэгч Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбооны 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр орон нутагт “Орон нутгийн бэлчээр ашиглалт, төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах нь” тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэхээр шалгарч 1.5 сая төгрөгийн санхүүжилт авч төслийг хэрэгжүүлсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- “Бэлчээрийн үнэлгээний өврийн дэвтэр”-ээс малчин иргэд бэлчээр ашиглалттай холбоотой мэдээллийг авснаар орон нутгаас гаргаж буй бэлчээр ашиглалттай холбоотой шийдвэр болоод төлөвлөлтөд хандах хандлага өөрчлөгдсөн.
- Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын бэлчээр ашиглалтын төлөвлөлтийн ажилд малчид эхлэх үйл явцаас дуусах хүртэл санал бодлоо хуваалцаж, шийдвэр гаргалтад хамтран оролцдог болсон.
- 2 багийн нийт 85 малчин иргэдийг зохион байгуулалтад оруулж “Бэлчээр ашиглалтын ажлын хэсэг”-ийг байгуулсан.

- БААХ-ийг бий болгосноор орон нутгийн бэлчээр ашиглалтын төлөвлөлтийг оновчтой төлөвлөх, иргэд төлөвлөгөөнд тусгагдсан шийдвэрүүдэд ухамсартай хандаж өмнөх үеэс бэлчээр ашиглалт зөв горимд шилжсэн.
- Бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулах чиглэлийн бүхий л ажлыг малчдын саналд тулгуурлан орон нутгийн төр захиргаагаар уялдуулдаг болсон.
- Бэлчээрийн менежмент өмнөх үетэй харьцуулахад сайжирсан.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Бизнес эрхлэгч болон мянгат малчин иргэд бэлчээрээ түрүүлж эзэмшин бусад иргэдийн ашиглах боломжийг хааж байгаа байдал. Гаднын сумдаас отор нүүдэл орж ирдэг болон гэрээ түрээсээр мал малладаг малчид бусад иргэдийн бэлчээр ашиглах эрхийг хааж, бэлчээрийн даац хэтэрч буй байдал. Бэлчээр ашиглалтын талаар хурал зохион байгуулахад өрхийн гишүүдийн ирц оролцоо дутуу байдгаас шалтгаалан ажил удааширах хандлага гарсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

хэлэлцэн баталж, шийдвэрлэсэн. Малчид ард иргэд дур зоргоор хашаа сараач барих асуудал байхгүй болсон сайн талтай болно. Сум орон нутгаас санаачилсан ажил, гаргасан шийдвэрийг дэмжиж байна.

Төмөрбулаг сумын 3-р багийн иргэн Ц.Нэргүй

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Сумын малчин иргэд орон нутгийн төлөөллийн байгууллагаас гарч буй шийдвэрт санал бодлоо тусгах болсон.

Малчин иргэд бэлчээр ашиглалттай холбоотой мэдээлэлтэй болсноор цаашид хийх үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдсэн.

Бэлчээр ашиглалттай холбоотой хийгдэж буй үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу, малчид болон төлөөллийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд илүү сайжирсан.

Хавсралт 1. Ажлын хэсэг байгуулах тухай А/23 дугаар тогтоол



Ажлын хэсэг байгуулах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь" төсөлд шалгарсан тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Швейцарын Хөгжлийн Агентлагийн Ногоон Алт, Малын эрүүл мэнд төслийг хэрэгжүүлэгч Монголын Бэлчээр Ашиглалтын Нэгдсэн Холбооны 3.0 сая

3. Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“БЭЛЧЭЭРИЙН АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ НЬ”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Л.БАТТУЛГА, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын засаг дарга.

Багш мэргэжилтэй. 1990-1997 онд багш, 1998-2007 онд бизнесмен, 2008-2009 онд ИТХ-ын дарга, 2009-2012 онд Засаг дарга, 2012-2016 онд ИТХ-ын дарга, 2016-2020 онд Тосонцэнгэл сумын Засаг даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 99050639

Цахим хуудас: Battulga7012@yahoo.com.

АГУУЛГА

Орон нутгийн бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах, тухайн үеийн нөхцөл байдлаас хамааран бэлчээр ашиглалтад оновчтой шийдвэр гаргах хүрээнд тус ажил хийгдсэн.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Бэлчээрийн цөлжилтийг бууруулах, малчдын дунд гардаг бэлчээр нутгийн маргааныг шийдвэрлэх асуудал тулгамдаж байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Завхан аймгийн малчид иргэдийг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оноос хойш тасралтгүй хэрэгжиж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Аймгийн ИТХ-ын V хуралдаанд “Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт, түүнийг нөхөн сэргээх, доройтлоос урьдчилан сэргийлэх арга замууд” сэдвээр Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт хөтөлбөртэй хамтран аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөд мэдээлэл хийлгэж, хэлэлцүүлсэн. Хуралдаанаас сумдын Хурлын дарга, Засаг дарга нарт бэлчээрийг зөв зохистой ашиглах, цөлжилтөөс хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

Бэлчээр ашиглалтыг төлөвлөх:

- Бэлчээрийг зөв зохистой ашиглахын тулд бэлчээр ашиглалтыг төлөвлөх нь чухал гэж үзсэн.
- Бэлчээрийг улирлын хуваарьтайгаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг гаргасан байх.
- Бэлчээрийн төлөв байдал чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн ашиглалтыг төлөвлөж байна.

Бэлчээрийн даац тогтоох:



- Багийн Засаг дарга: Тухайн сум, багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгуулахаар дор дурдсан асуудлыг тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор БИНХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. Үүнд:
- Малчин өрх бүрийн өвөлжүүлэх малын тооны дээд хязгаар
- Малчин өрх бүрийн малын тоог хонин толгойд шилжүүлснээр бэлчээрийн даацаас хэтэрсэн болон дутуу байгаа тооцоолол
- Малчин өрхийн бэлчээрийн даацаас илүү гарсан хонин толгойд шилжүүлсэн малын тоо толгойг эдийн засгийн эргэлтэд оруулах, цөөн тоотой мал бүхий малчин өрхөөр маллуулах, өөр нутагт отор нүүдэл хийх болон бусад арга хэмжээг авах зохицуулалт
- Багийн ИНХ дээрх асуудлыг жил бүрийн 10-р сарын 15-ны дотор хэлэлцэж шийдвэрээ сумын Засаг даргад хүргүүлнэ.
- Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн ИНХ-ын саналыг тусган харьяалах сумын ИТХ батална.

Бэлчээрийг ашиглуулах:

- Бэлчээр ашиглагчдын хэсэг, түүний гишүүн малчин дараах 9 эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- Бэлчээрийн сан:
- Бэлчээр ашиглагчдын хэсэг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 51.1-д заасныг үндэслэн бэлчээрийг нөхөн сэргээх, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон бусад үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, гишүүн малчин өрхдөө дэмжлэг үзүүлэх зорилгоор Бэлчээрийн сан байгуулж болно.
- Бэлчээрийн сангийн хөрөнгийг зөвхөн дараах зүйлд зарцуулна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

“Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт, түүнийг нөхөн сэргээх, доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 64.5 сая төгрөг, Ногоон алт төслөөс 7 сая, Улс, орон нутгийн төсөв, ОНХС 30.5 сая, бусад эх үүсвэрээс 25,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

Аймгийн ИТХ-ын VI хуралдаанаар “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах үлгэрчилсэн журам”-ыг баталж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүрдгүүлсэн. Энэ журмаар бэлчээр ашиглалтыг тухайн орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхад суурилсан аргачлалаар төлөвлөх, бэлчээрийг түүний нөөц, даацад нь тохируулан байгалийн жамаараа нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, төлөвлөгөөний дагуу бэлчээрийг улирлын хуваарьтайгаар зүй зохистой ашиглаж, хамгаалах дадлыг төлөвшүүлэх, нутгийн удирдлага, бэлчээр ашиглагчдын хооронд үүсэх харилцаа зохицуулагдсан.

- Баянтэс сумын Жавхлан багийн Өвөр хөндий БАХ-ийн Ар хөндийн хаваржаа намаржааны бэлчээрт Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шинээр инженерийн хийцтэй гүний худаг гаргаж ашиглалтгүй байсан 4500 га бэлчээр ашиглалттай боллоо.
- Сантмаргаз сумын орон нутгийн хөгжлийн сангаар 5 сая төгрөгөөр Дөрөлжийн улаан, Хавтгай, Ихмаргаз БАХ-ийн хаваржаа, намаржааны бэлчээрийн хуучин гар худгуудыг сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг сайжруулсан байна.
- Цагаанчулуут сумын Дэлгэр багт ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8 сая төгрөгийн төсөвт өртгөөр хөв цөөрөм байгуулах ажлыг эхлүүлээд байна Хөв цөөрөм



байгуулагдсанаар тус БАХ-ийн бэлчээрийн усан хангамж сайжирч бэлчээр ашиглалттай болсон юм.

- Ургамал сумын Аргалын хар БАХ –ийн бэлчээрт усан хангамж сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор ОНХС-аас 2 сая төгрөгөөр уст цэгийн хайгуул хийлгэх, БАХ-ийн өвөлжөөний бэлчээрт байрлах хуучин худгийг сэргээн засварлахад 2 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна .
- Дөрвөлжин сум Буурал багийн бэлчээр ашиглалтын хэсэг журамд заасны дагуу Буурал багийн нутагт Туулай орчмын нутгийн бэлчээрийг ашиглалгүй өнжөөсөн.
- Дөрвөлжин сумын Таван толгой багт “Бор гуяны худаг”, Буурал багийн нутаг “Таван харын доод булцууны худаг”, Цогт багийн нутагт Баян улааны баруун хойд хэсэгт “Тардын худаг”, зэрэг худгуудыг шинээр гаргаж ашиглагдахгүй алсын бэлчээрийг ашиглаж байна.
- Шилүүстэй сум “Ногоо алт” төслөөс 5.0 сая, сумын орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг гарган бэлчээрийн сантай болсон.
- Малын эрүүл мэндийн загвар сум болох Баянтэс, Сантмаргаз, Эрдэнэхайрхан, Шилүүстэй сумууд сумынхаа сумын сүргийн эргэлтийн төлөвлөгөөг боловсруулан малчдад сургалт хийж танилцуулснаар 2019 онд зах зээлд борлуулах малын тоог гаргаж Эрдэнэхайрхан сум 7415 толгой мал, Шилүүстэй сум 6729 толгой мал, Баянтэс сум 17056, Сантмаргаз сум 18209 толгой мал аймгийн хэмжээнд бүгд 97057 толгой мал буюу 730 тонн мах зах зээлд борлуулсан.
- Асгат сумын Аргалант суварга хоршоо 80 га талбайд овьёос, улаан буудай тариалж 80 тонн, Цэцэн-Уул сум БАХ-ийн малчид хамтран 9 га талбайд овьёос тариалж 18 тонн малын тэжээл тус тус хураан авсан.
- Мал эмнэлгийн гарал үүслийн баталгаажуулалтын системийг Баянтэс, Сантмаргаз, Эрдэнэхайрхан, Шилүүстэй сумуудад нэвтрүүлж Ногоон алт төслийн хүрээнд гарын авлага тарааж малчид зах зээлд малаа борлуулахдаа малын эрүүл мэндийн гарал үүслийн цахим гэрчилгээ авч 3800 гаруй малчин өрх цахим гэрчилгээгээр малаа зах зээлд гаргаж борлуулсан байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Санхүүгийн асуудал болон зохион байгуулалтын ажил удаашралтай байдал.


ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Хавар, намар, өвөлд талхлагдаж цөлжиж байгаа Буурал багийн “Туулайт” орчмын нутгийн бэлчээрийг өнжөөж байгаа нь маш зөв. Энэ нутагт хэдэн жилийн өмнө ургадаг байсан өрхөг, хялгана, шаваг зэрэг бэлчээрийн ач холбогдолтой ургамал сэргэж ургах нөхцөл бүрдэж байна. Буурал багийн нутаг “Таван харын доод булуунд худаг” шинээр гаргасан нь Тавантолгой багийн малчид тэр худгаас ойр орчмын элсний бэлчээрийг хавар, намрын улиралд ашиглах боломжтой болж бэлчээрийн хомсдолоос гарч байгаа сайн арга хэмжээ юм.

Дөрвөлжин сумын Буурал багийн малчин Д.Сумъяабазар

Мал ахуйг хамгийн сайн сайхан байлгах зүйл бол бэлчээр юм. Жилээс жилд бэлчээр маань цөлжиж малын тоо хэт ихсэж бэлчээр эхээр талхлагдаж байна. Иймд малчдаас малын хөлийн татвар авах, бэлчээрийн сантай болгох, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах арга хэмжээ авч байгаа нь маш зүйтэй ажил болж байна.

Тосонцэнгэл сумын Рашаант багийн малчин П.Алимаа




СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Малчдад бэлчээр нутгаа зөв зохистой ашиглах болон одоогийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгсөн.

Орон нутгийн төлөөллийн байгууллага нь малчидтай хамтран бэлчээр ашиглалтыг төлөвлөх, бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийг ашиглуулах гэсэн үе шаттайгаар үйл ажиллагааг зохион байгуулсан нь үр дүнтэй болсон.

Бэлчээр ашиглалтын асуудалд анхаарал хандуулснаар дагах асуудал болох худгуудыг сэргээж, зарим тохиолдолд шинээр гаргасан нь малчдын тулгамдаж буй нэгэн асуудлыг цогцоор шийдсэн.

Хавсралт 1. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах үлгэрчилсэн журам батлах тухай 41 дүгээр тогтоол



1. Улаанбаатар хот Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

“ТА ДОХЬ-БИ ЗАЛГАЯ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Т.УЛАМБАЯР, Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Иргэний оролцоо, олон нийттэй харилцах хэлтсийн дарга. Эрхзүйч мэргэжилтэй. Нийслэлийн Татварын газар мэргэжилтнээр 3 жил, тус хэлтсийн даргаар 2013 оноос одоог хүртэл ажиллаж байна.

Холбоо барих утас: 99040100

Цахим хаяг: Ulambayar0100@gmail.com

АГУУЛГА

Дүүргийн ИТХ-аас иргэдэд мэдээлэл шуурхай хүргэх, иргэдийн санал хүсэлтийг авах зорилгоор 2016 оноос Жи-мобайл, Юнител, Мобиком, Скайтел 4 үүрэн холбооны “Та дохь-Би залгая” утас ажиллуулсан.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Дүүргийн ИТХ-аас зохион байгуулж буй арга хэмжээнд иргэдийн оролцоог хангах, үйл ажиллагааны талаарх мэдээллийг шуурхай хүргэх, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах асуудал тулгамдаж байсан.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Чингэлтэй дүүргийн иргэдийг хамруулав.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2016 оны 1-р сараас 2020 оны 4 сар хүртэл тасралгүй хэрэгжсээр байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Мэдээлэл харилцаа, үүрэн холбооны технологийг ашиглан иргэд олон нийттэй харилцах боломжийг бүрдүүлсэн. Чингэлтэй дүүргийн хэмжээнд 19 хороонд тус бүр 1 утас ажиллуулан Иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөх, санал хүсэлтийг хүлээн авах, гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэхээр ажиллаж байна.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн даргын 2016 оны 10 дугаар тушаалаар 1-19 дүгээр хорооны иргэдийг сургалт, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллээр шуурхай хүргэх зорилгоор хороодын Иргэний танхимд Жи-мобайл, Юнител, Мобиком, Скайтел 4 үүрэн холбооны утсыг ажиллуулсан.
- “Та дохь-Би залгая” утсыг утасны дугаарын сүүлийн цифрийг тухайн хорооны дугаартай адилтган авч Иргэний танхимын ажилтнуудад хариуцуулан хүлээлгэн өгсөн.
- Хорооны Иргэний танхимын ажилтнууд тус утсанд иргэдээс ирсэн дуудлагыг тасалж, эргэн холбогдож мэдээлэл хүргэн ажиллах талаар иргэдэд сурталчилгааны хуудсыг хэвлүүлэн айл өрхөд хүргүүлж, сурталчилснаар энэхүү үйлчилгээ тогтвортой хэрэгжих эхлэл тавигдсан.

- Иргэдийг мэдээ мэдээллээр хангах, санал, хүсэлт, гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага мэдээлэл хүлээн авах үүрэн холбооны утасны шинэчлэлийг хийж, Жи-мобайл, Юнител, Мобиком, Скайтел 4 үүрэн холбооны утсыг 2018 онд бусад үүрэн холбооны сүлжээнд үнэгүй ярих нөхцөлтэйгөөр нэг төрлийн Мобикомын үүрэн холбооны сүлжээний утсанд нэгтгэн Иргэний танхимын ажилтнуудад хариуцуулан өгсөн.
- Иргэдийг гэмт хэрэг, зөрчлийн талаарх ирүүлсэн мэдээллийг холбогдох байгууллагуудад хорооны Иргэний танхимын ажилтан тухай бүр мэдэгдэж, энэ талаар иргэнд мэдэгдэж ажилладаг. Мөн тус утсыг ашиглан иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч ажиллах ажлыг зохион байгуулан ажиллаж, дүн мэдээг хэлтэст нэгтгэн ажиллаж байна.
- “Та дохь-Би залгая” утсыг хариуцан ажиллуулж байгаа хорооны Иргэний танхимын ажилтан иргэдээс ирүүлсэн дуудлага бүрийг бүртгэл хяналтын дэвтэрт тэмдэглэж, мэдээллийн агуулга, ярианд зарцуулсан хугацааг тухай бүр тэмдэглэж ажилладаг. “Та дохь-Би залгая” утсыг хариуцсан ажилтнууд Төрийн үйлчилгээг тухайн үүрэн холбооны багцын ярианы төлбөрт багтаан ажилладаг.



САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Та дохь- Би залгая аяныг зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийг Чингэлтэй дүүргийн ИТХ-ын ажлын албаны даргын 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10 дугаар тушаалаар шаардагдах санхүүжилтийг Хурлын техник, багаж хэрэгслийн зардлаас гаргасан. 1 хорооны “Та дохь-Би залгая” утасны багц үйлчилгээ 31650 төгрөгийг тухайн гэрээт байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг хийж гүйцэтгэж байна. Нийтдээ 19 хороонд тус утсыг ажиллуулж байна.

ХҮРСЭН ҮР ДҮН

Дүүргийн ИТХ-аас зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээллийг “Та дохь-Би залгая” утсаар мэдээлэл хүргэж оролцуулснаар иргэдийн оролцоо дээшилсэн.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Иргэд тухайн утасны талаар мэдээлэлгүйгээс төсвийн зардлыг үр ашиггүй зарцуулах эрсдэл гарч байсан.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Би анх 2018 онд 1072 хувьцааны бүртгэл хорооны иргэний танхимаар хийгдэж байгааг сонсоод тэр талаар лавлахаар 94110378 утас руу залгаж мэдээлэл авсан. Мөн хог ачихгүй байгаа талаар гомдол хэлэхэд түргэн шуурхай үйлчилж асуудлыг шийдэж өгсөн. Түүнээс хойш дүүрэг, хороонд хийгдэж байгаа ажлаас гадна бусад мэдээлэл авах, лавлах зүйл гарвал энэ дугаарт залгадаг болсон. Мөн энэ дугаарт залгахад буцааж залгадаг юм байна. Яаралтай асуух зүйл гарахад энэ утас руу залгадаг. Жишээ нь: Халамжийн төслийн талаар, бүртгэл мэдээлэл, хог ачих тухай, тэр ч байтугай хуулийн талаар лавлах тохиолдолд хариу өгдөг юм. Цаашид энэ утас ажиллаж л байвал иргэд бидэнд хэрэгтэй байна. **ЧД-ийн 18 дугаар хорооны иргэн Д.Лхагвасүрэн**

ДҮҮРГИЙН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Дүүргийн хэмжээнд иргэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, зөрчлийн талаар санал, хүсэлтээ өгөх, хэлэх боломжтой болсон.

Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтэд тулгуурлан төрийн байгууллагууд үйлчилгээ, үйл ажиллагаагаа сайжруулсан.

Төрийн үйлчилгээний талаарх үнэн зөв мэдээллийг богино хугацаанд, найдвартай эх сурвалжаас авах болсон.

2. Төв аймгийн Алтанбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ХОГ ХАЯГДЛАА ХОЁРДОГЧ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛГОЁ”

САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ



Ц.ПҮРЭВДОРЖ, Төв аймгийн Алтанбулаг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга. Батлах Хамгаалахын Их Сургуульд Эрхзүйч мэргэжил эзэмшсэн. 1997-2005 онд Төв аймгийн Алтанбулаг сумын Төрийн захиргааны хууль эрхзүйн мэргэжилтэн, 2005 оноос Алтанбулаг сумын ИТХ-ын Нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Холбоо барих утас: 99739386,

Цахим хаяг: altanbulag.puujee@gmail.com

АГУУЛГА

Орон нутаг дах хаягдал цаас болон төрийн байгууллагуудын 10 жилийн турш захиалсан сониныг дахин боловсруулах үйлдвэрт өгч, ашигласнаар шувууны үүр хийсэн байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хогийн цэгт цаас их хаягдаж, тэдгээр цаасыг шатаах нь агаар бохирдуулахаас гадна гал түймэр гарах эрсдэл их байдаг. Сумын соёлын төвд байгууллагуудын 10 гаруй жил захиалсан сониныг шилжүүлсэн бөгөөд зориулалтын бус өрөөнд хураалгаатай байдаг. Тус хадгалах өрөө нь багтаамж муутай бөгөөд архивын материалуудыг хадгалах хугацаа дууссан байсан. Архивд хураагдсан сониныг цэгцлэх, соёлын төвийн нэг хэсгийг суллаж зориулалтын дагуу ашиглах мөн сумын бүс нутгийн орчимд байгаа цаасан хаягдлыг устгах шаардлагатай болсон.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Төрийн алба хаагчид болон иргэдийг хамруулан орон нутгийн цаасан хог хаягдлыг цуглуулах, архивласан сониныг цэгцлэх ажлуудыг хийсэн.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2019 оны 2-р сараас 2019 оны 03-р сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

2019 оны 2-р сард сумын нутаг дэвсгэрт хаягдал цаас цуглуулах аян зохион байгуулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- ИТХ-аас 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Аян өрнүүлэх” тухай тогтоол гарснаар Алтанбулаг сумын хэмжээнд 1 сарын хугацаатай орон нутагт цаасан хог хаягдлыг цуглуулах аян өрнүүлсэн.
- “Хог хаягдлыг цуглуулах” аян өрнүүлэх тухай мэдээллийг орон нутгийн төрийн байгууллага болон олон нийтэд түгээсэн.
- Алтанбулаг сумын бүс нутагт байсан хаягдал цаасыг нэг цэгт цуглуулсан.



- Хаягдал цаасыг үйлдвэрт нийлүүлэх ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарч байгууллагууд хаягдал цаасаа хогийн цэгт биш 2 дох түүхий эд бэлтгэх цэгт тээвэрлэн нийлүүлсэн.



Төв аймгийн Алтанбулаг сумын хаягдал цаасыг цуглуулах үйл явц

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Хог хаягдлыг үйлдвэрт тээвэрлэн нийлүүлэхэд 10 л бензин шаардагдсаныг ИТХ-ын зардлаас шийдвэрлэсэн.

ХҮРСЭН ҮР ДҮН

- Сумын ард иргэд нэгдмэл нэг үйл ажиллагаанд хамтран, нэг нэгнээ дэмжин оролцох нь үр дүнтэй ажил болдог талаар ойлгосон.
- Хаягдал цаасыг байгууллагууд сумын түүхий эд ангилах төвд нийлүүлж тэндээс Хан уул дүүрэг “Шувуун фабрик”-ийн өндөгний үүр хийдэг үйлдвэрт нийлүүлсэн нь үндэсний үйлдвэрлэлийг дэмжихүйц ажил болсон.
- Орон нутгийн бүс орчимд цаасан хог хаягдалгүй болсон нь хүрээлэн буй орчны бохирдлыг багасгасан.
- Монгол Улсын хувьд бүх түвшний төрийн байгууллагуудаас олон жил үр ашиггүй хадгалсан цаасан хаягдал маш ихээр гардаг. Тэдгээрийг энэ санаачилгатай адил хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд болон хувь хүнд өгөх замаар үр ашигтай, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хор нөлөөгүйгээр устгаж болохыг харуулсан нь үр өгөөжтэй ажил болохыг харуулж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Олон нийтийг идэвхжүүлэн цаасан хог хаягдлыг цуглуулах аянд нэгдүүлэх, сайн дураар нэгдэн оролцуулахад нэлээд бэрхшээлтэй байсан. “Шувуун фабрик”-ийн өндөгний үүр хийдэг үйлдвэр нь шохойтой цаас авдаггүй учир 2 тонн гаруй цаас буцаж ирсэн.

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Орон нутагт хурсан цаасан хогийг дахин боловсруулалтад оруулж дахин ашиглах болсон.

Орон иргэд нутгийн орчныг цэвэрлэх, цэвэрхэн орчин бүрдүүлэхэд гар бие оролцсон.

Хавсралт 1. Аян өрнүүлэх тухай 07 дугаар тогтоол


МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 02 өдөр Дугаар 07 Туул

Аян өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт 2019 оны 02-р сард хаягдал цаас цуглуулах аян зохион байгуулсугай.
2. Энэхүү аяны хүрээнд хаягдал цаасыг цуглуулан хадаглаж, цаас цуглуулах өдөр төвлөрүүлэх цэгт тушааж энэхүү аянд нэгдэхийг сумын нийт иргэдэд уриалсугай.
3. Хаягдал цаасыг гудамж талбайд хөглөрүүлэн байгаль орчны өнгө үзэмж дарах, цуглуулан шатаах аргаар агаар, орчинг бохирдуулах хог хаягдал биш, 2 дох түүхий эд болгох чиглэлийн сургалт сурталчилгааг өрнүүлэн энэ аянд нэгдэхийг нийт төрийн албан хаагчдад зөвлөсүгэй.
4. Уг аяныг 2019 оны 2-р сарын турш зохион байгуулж, 2019 оны 02-р сарын 27 ны "Лхавга" гарагт 1 цэгт төвлөрүүлэн, цаас худалдан авах цэгт хүргэхийг сумын Засаг дарга /Д.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА  Н.БАТМӨНХ

My doc: Togtool 2018
111028

3. Ховд аймгийн Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

“ӨВС ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛСЭН”**САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Ц.ГАНБОЛД, Ховд аймгийн Мөнххайрхан сумын ИТХ-ын Төлөөлөгч, сумын орлогч дарга. Соёлын байгууллагад 13 жил Соёлын төвийн хөгжмийн багш, эрхлэгчээр, 8 дахь жилдээ сумын Засаг даргын орлогчоор ажиллаж байна. ИТХ-ын Төлөөлөгчөөр 3 дахь удаагаа сонгогдон ажиллаж байна.

Холбоо барих утас: 95295656

Цахим хаяг: ganboldtseerew@gmail.com

АГУУЛГА

Ховд аймгийн Мөнххайрхан сумын малчин иргэдээс бага хэмжээний хуримтлал үүсгэн малын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх санаачилгаа гаргасан. Өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд малчдын оролцоог нэмэгдүүлэх, санаачилгаа гарган дэмжин ажиллах.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Сум хэмжээнд өвч тэжээлийн нөөц багатай, хадлан тэжээл бэлдэх талбай багатай тул тус орон нутгийн хувьд өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт нь тулгамдсан чухал ажлуудын нэг болоод байна. Малчдаас жил бүр өвс тэжээлээ хангалттай нөөцлөхөд сум орон нутаг анхаарч ажиллах хэрэгтэй байна гэсэн хүсэлтүүд ирдэг байсан. Өвөлжилт, хаваржилт хүндрэх цаг үед малчид өвсний нөөц багатай байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Ховд аймгийн Мөнххайрхан сумын малчин иргэдийг хамрууллаа.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2018 оноос хойш тасралгүй хэрэгжүүлж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

Малчдын зөвлөгөөн зохион байгуулан өвөлжилт, хаваржилт хүндрэх цаг үед өвсний нөөц багатай байгааг танилцуулан, малчдын хандив санаачилгаар өвс, тэжээлийн нөөцийн санг бүрдүүлэх боломжтойг хэлэлцэн уриалга гаргасан. ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулж ажиллаж байна. Малын тоо толгойг хонин толгойд шилжүүлэн малаас төгрөгөөр тооцож нөөцийн сангаа бүрдүүлэх шийдэлд хүрсэн. Оруулсан хувь хэмжээнээс хамаарч 3 дахин нэмэгдүүлсэн хэмжээний өртөгтэй тэнцэх хэмжээний өвс тэжээлийг хамгийн хямд үнээр авах эрх бүрдэнэ. Малчдын зөвлөгөөний хүрээнд хамтран ярилцсаны үндсэн дээр малчин, мал бүхий өрх бүр нэг малаас хонин толгойд шилжүүлснээр 100 төгрөгийг нэгдсэн фондод оруулах, захиргааны байгууллага өвс тэжээлийг олох, тээвэрлэх, худалдан авсан үнэ дээр зөвхөн замын зардлыг шингээж малчдын гар дээр хямд үнэтэй, чанартай өвс тэжээлийг нийлүүлэхээр шийдсэн

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Малчдын зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн малчдаас уриалга гаргасан.



- Малчдын гаргасан уриалгыг ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлэн журам батлуулсан.
- Баталсан журмаа хэрэгжүүлж багийн дарга нар хариуцан нөөцийн сангаа бүрдүүлсэн.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨСӨВТ ӨРТӨГ

Санхүүгийн асуудлыг малчид, төр захиргааны байгууллагын хамтын санаачилга шийдвэрийн үндсэн дээр бий болгосон.

ХҮРСЭН ҮР ДҮН

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн цаг үед, бусад өвс тэжээлийн шаардлага гарсан цаг хугацаанд иргэд хямд үнээр нөөцийн өвс авах боломж бүрдсэн. Зудын үед малын хорогдол бага гарч байна. Нэг өвс 15000 төгрөг байсан бол одоогийн байдлаар 6500 төгрөгөөр малчдын гар дээр хүрч байна. Малчид бизнесменүүдийн гар дамжсан үнэтэй өвс, тэжээл авч хэрэглэх нь багассан. Санаачилга хэрэгжихээс өмнө 4 сая төгрөгийн нөөцийн сантай байсан одоо 10 сая төгрөгийн сантай болсон байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДСАН БЭРХШЭЭЛ

Зарим малчин иргэд хувь оруулсан мөнгөнийхөө хэмжээнд тохируулан өвс, тэжээл үнэгүй авна гэж буруу ойлгох, зарим цөөн тооны малтай иргэд хувь хөрөнгөө нийлүүлэхгүй байх зэрэг бэрхшээл тулгарч байна. Хадлангийн талбай муутай, малын тоо өсөж бэлчээрийн даац хэтрэлттэй болсон, өвс тэжээлийн нөөц хомсдох, их хэмжээгээр татан төвлөрүүлсэн өвс тэжээлийг хамгаалах агуулах байхгүйн улмаас чанараа алдах зэрэг эрсдэлүүд байна.

ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН СЭТГЭГДЭЛ

Хаваржилт хүндэрсэн жилүүдэд сумын өвс, тэжээлийн нөөц хүрэлцээгүйн улмаас бизнесменүүдээс өндөр үнэтэй өвс, тэжээлийг авдаг байсан одоо харин нөөцийн сан нэмэгдэж өвс тэжээл боломжийн үнэтэй ирж байна. Манай нутгийн хувьд хадлан тэжээл бэлдэх талбай бага, ургамлын гарц тачир гардаг тул өвс, тэжээлийг малдаа тохируулан бэлдэх хэрэгтэй байдаг. Малчдын зөвлөгөөнөөс гарсан уриалга ажил хэрэг болоод малчин бидэнд дэмтэй байгаад баяртай байна.

Борт багийн иргэн "Аймгийн аварга малчин" Ч.Бямбадорж

СУМЫН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Малчид цаг үеийн байдлаас шалтгаалсан үед өвсний нөөцтэй байж, зах зээлийн үнэнээс хямдаар авах боломжтой болсон.

Малчин өрхүүд байршлаас хамааран баг, бүлэг үүсгэн хамтран өвч тэжээлийн асуудлаа шийдэх санаачилга гаргасан.

Орон нутгийн хувьд өвөлжилт, хаваржилтын үед өвч, тэжээлд зориулж төрөөс төсөв санхүү гаргах шаардлагагүй болсон.

4. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал**“АЮУЛГҮЙ, ЭРҮҮЛ НИЙГМИЙГ БҮТЭЭЦГЭЭ”****САЙН ТУРШЛАГЫГ САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

Э.ГАНБАТ, Улаанбаатар хотын СБД-ийн ИТХ-ын дарга. 2016 оны дүүргийн орон нутгийн сонгуулиар 16 дугаар хороонд Ардчилсан намаас нэр дэвшиж дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдож мөн 2017 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр дүүргийн ИТХ-ын Анхдугаар хуралдаанаар ИТХ-ын даргаар сонгогдон ажиллаж байна.

Цахим хаяг: ganbat@sbdCouncil.gov.mn, deganbat@yahoo.com

АГУУЛГА

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт гэмт хэргийн ослоос хамгаалах, архи тамхигүй эрүүл нийгмийг бүтээх зорилгоор ЕБС болон Их, дээд сургуулийн оюутнуудад зорилтот ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлсэн байна.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1. Сүхбаатар дүүрэгт сүүлийн жилүүдэд зам тээврийн осолд өртөх хүүхдийн тоо эрс өссөн,
2. Эрүүл, зөв амьдралын хэв маягийг бий болгох, өсвөр насныхан болоод оюутан, залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний хор уршгийг таниулах, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд мэдээлэл өгөх, хор уршгийн талаар таниулах шаардлага бий болсон.

ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Сүхбаатар дүүргийн ЕБС-ийн сурагчид, Их дээд сургуулийн оюутнууд.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА

2017 оноос 2019 онуудад тасралтгүй хэрэгжүүлж байна.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН АРГА ХЭРЭГСЭЛ

1. Зам тээврийн ослоос хүүхэд, залуусыг хамгаалах зорилгоор “Дугуй эргүүл” арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн. Мөн ЕБС-ийн сурагчдад зам тээврийн ослоос сэргийлэх үүднээс цацруулагчтай ханцуйвчаар хангах ажлыг зохион байгуулсан.
2. ЕБС-ийн сурагч, Их дээд сургуулийн оюутан залууст архи, мансуурлын хор нөлөөг таниулах, мэдээлэл өгөх ажлыг хүүхэд, залуусын оролцоотойгоор мэтгэлцээн, сургалт, хэлэлцүүлэг, дэвжээ гэх мэт үйл ажиллагааг “**төр-иргэн-хүүхэд**”-ийн оролцоотойгоор зохион байгуулсан.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ ЯВЦ БА АЛХМУУД

- Бага насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор замтай ойр байрлах, зам тээврийн осол, хэрэг гарч болзошгүй эрсдэлтэй нийслэлийн



тэргүүний ерөнхий боловсролын 58 дугаар сургуулийн 1-ээс 5 дугаар ангийн нийт 4000 сурагчдад гэрэл цацруулагчтай ханцуйвчийг бэлэлэлсэн.

- Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн үйл ажиллагааг дэмжин иргэдэд цаг алдалгүй хурдан шуурхай үйлчлэх зорилгоор “Дугуйт эргүүл” ажиллахыг анхлан санаачлан хэрэгжүүлж эхлээд байна. Сүхбаатарын талбай, Цэрэндоржийн гудамж, Сөүлийн гудамж, Энхтайвангийн өргөн чөлөөнд дугуйтай эргүүл ажилласан.
- Цагаан сарын баярын өдрүүдээр нэмэлт эргүүлийн автомашин ажиллуулав.
- Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн албан хаагчийг ОХУ-ын Краснодарын Их сургуульд “Терроризм болон бусад хүч хэрэглэсэн экстремизмийн илрэлүүдтэй тэмцэх орчин үеийн арга хэлбэрүүд” сэдэвт сургалтад хамруулсан.
- Дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн 600 гаруй сурагчдад хар тамхи, мансууруулах бодисын хор уршгийн талаар “Бид татгалзаж байна” өдөрлөгийн арга хэмжээг зохион байгууллаа.
- Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 2017 оны 06 дугаар сарын 08-11-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан дэлхийн 51 орны 3500 гаруй гишүүн оролцсон “Манлайлагч, ажил хэрэгч залуучуудын бизнес уулзалт”, АСПАК олон улсын арга хэмжээний аюулгүй байдлыг ханган, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран зохион байгуулж ажиллав.
- 2.2.8. “Хуулиа мөрдө-21” аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Сүхбаатар дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс хамтран Сүхбаатар дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулиудын оюутнуудын дунд “Архи, мансуурлын хор хөнөөлийн эсрэг хамтдаа” сэдэвт дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.
- Сүхбаатар дүүргийн ИТХ-ын дарга Э.Ганбатын ивээл дор дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын мэтгэлцэгч сурагч, багш нарын мэтгэлцэх чадварыг ахиулах, үр дүнтэй суралцах арга барилыг хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээ болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар багш, сурагчдад тодорхой ойлголт өгөх, тайлбарлан таниулах, зорилго бүхий Сүхбаатар дүүргийн аварга шалгаруулах мэтгэлцээний тэмцээн зохион байгуулагдсан.
- Сүхбаатар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс санаачлан замын хөдөлгөөний аюулгүй байдал, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд онцгой анхаарч, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах урт богино хугацааны хөтөлбөр батлах, зөвлөл байгуулах зорилгоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгуулсан.



Сүхбаатар дүүргийн ИТХ-ын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц

ХҮРСЭН ҮР ДҮН

- Сүхбаатар дүүргийн газар нутаг дахь сурагчдыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн,
- “Дугуйт эргүүл” ажиллуулснаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэх болсон,
- Сурагч болон оюутан залуус архи, мансууруулах бодисын хэрэглээний хор нөлөө, түүний уршгийг сургалт, хэлэлцүүлэг, тэмцээн уралдаан гэх мэт нийгмийн оролцоот үйл ажиллагаагаар дамжуулан суралцсан,
- Дүүргийн хэмжээнд иргэд, төрийн байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирсан,
- Дүүргийн иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажиллах болсон.

ДҮҮРГИЙН ИРГЭД, ОРОН НУТАГТ БИЙ БОЛСОН АШИГ ТУС

Дүүргийн хэмжээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил нь үр дүнтэй болж, иргэдийг мэдээ, мэдээллээр хангасан.

Иргэд цагдаагийн байгууллага болон тэдгээрийн талаар богино хугацаанд илүү мэдээлэлтэй болсон.

Дүүргийн төрийн байгууллагаас иргэд болон бусад иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад туршлагажсан.

БҮЛЭГ 3. ИТХ-ЫН САЙН ТУРШЛАГЫГ СУРТАЛЧЛАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛГА БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн амьдрал олон талтай, аймаг, сум бүрд шийдвэрлэвэл зохих өөр өөрийн өвөрмөц асуудал байдаг. Гэвч аймгаараа, сумаараа цуглараад байх боломж үгүй учир тэдэнд өөрсдийн төлөөлөгчдийн буюу түүнийг “хураангуйлсан” байгууллага, бас ажлын мэргэшсэн алба зайлшгүй хэрэгтэй болдог. Иймийн тулд төлөөллийн ардчиллын зарчмыг хэрэгжүүлэх замаар иргэдийг төлөөлөх хэлбэр бол нутгийн өөрөө удирдах байгууллага юм. Энэхүү НӨУБ болох бүх шатны ИТХ нь Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд тухайн орон нутгийн иргэдийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх, иргэдийн эрх ашигт нийцүүлэн, тодорхой судалгаа, үндэслэлд тулгуурлан зөв оновчтой шийдвэр гаргах, гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх, гарах үр дүнг нь хариуцах, хэрэгжилтэд хяналт тавих чадвартай байх нь чухал юм. ИТХ эдгээр чадварыг бэхжүүлэхэд тухайн орон нутгийн эдийн засаг, санхүүгийн нөөц, иргэд болон тэдгээрийг төлөөлж буй төлөөлөгчдийн мэдлэг туршлага, иргэд, улс төрийн хүчнүүд, нийгмийн бүхий л бүлэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагаа, ардчилсан зарчмаар шийдвэр гаргах, иргэдийн идэвх оролцоог хангах арга туршлага, хүсэл эрмэлзэл зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг.

Дэлхийн улс орнууд нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, НӨУБ-ын чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Монгол Улсын хувьд ч 1992 оноос хойш сонгогдсон бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал буюу “төлөөллийн байгууллага”-уудын чадавхыг бэхжүүлэхэд тухайн институтын өөрийн хүчин чармайлтаас гадна төр засаг, олон улсын байгууллагууд, ТББ-ын оролцоо дэмжлэг чухал хувь нэмэр оруулсаар ирсэн. Ялангуяа олон улсын байгууллагуудын урт хугацааны зорилтот төсөл хөтөлбөрүүд үр нөлөөтэй байсны нэг нотолгоо бол уг судалгаанд аймаг, сум, дүүргийн ИТХ-аас ирүүлсэн шаардлага хангасан “сайн туршлага”-ын багагүй хувийг олон улсын байгууллагын дэмжлэг санхүүжилттэй явагдсан сургалт, төсөл хөтөлбөрүүд эзэлж байна.

ИТХ-ыг чадавхжуулах, НӨУБ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох нэг чухал хэлбэр бол ИТХ-ын сайн туршлагыг судлах, сурталчлан таниулах үйл ажиллагаа юм. Аливаа институци, хүмүүсийн сайн туршлагыг олж нээх, судалж шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх нь нарийн дэс дараалал, арга аргачлал, мэдлэг чадвар шаардсан нарийн төвөгтэй практик үйл явц байдаг. Түүнчлэн дээрх үйл ажиллагааг үр дүнтэй болгох ажил бол тухайн сайн туршлагуудыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, бодит амьдралд нэвтрүүлэх, нутагшуулах үйл ажиллагааг явуулах явдал юм. Улс орнуудад сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр янз бүрийн арга хэлбэрийг хэрэгжүүлж байна.

Тиймээс бид энэхүү санал зөвлөмжид **бусдын сайн туршлагыг авч хэрэгжүүлэх арга зүй болон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх** гэсэн хоёр чиглэлээр дараах зүйлийг зөвлөмж болгож байна.

1. Сайн туршлагыг хэрэгжүүлэх арга зүй

Энд өгүүлж буй арга, аргачлал нь бусдын сайн туршлагыг өөрийн орон нутаг, ИТХ-ын онцлог, нөхцөл байдалд тохируулан авч хэрэглэхэд дөхөм үзүүлэхээс гадна судалгаа шинжилгээ, нотолгоонд суурилах тул аливаа алдаа эрсдэлээс сэргийлж, бүтээлчээр нутагшуулахад тус болно гэж үзлээ.

Европын бүс нутгийн чуулга (Assembly of European Regions), “Орон нутаг ба идэвхтэй иргэн” сүлжээ (RURACT - Rural areas and active citizenship)-нээс гаргасан “Сайн туршлагыг хэрхэн нэвтрүүлэх вэ?” гарын авлагад сайн туршлагыг нэвтрүүлэх дараах аргачлалыг боловсруулсан байна.

1-р шат	2-р шат	3-р шат	4-р шат	5-р шат
•Хэрэгцээ шаардлагаа тодорхойлох	•Сайн туршлагыг судлах	•Харьцуулсан шинжилгээ хийх	•Шилдэг туршлагыг сонгох	•Төслийн баг бүрдүүлэх

Зураг 4. Эх сурвалж: *Rur@ct methodological guide*, 2013 <https://www.printfriendly.com/p/g/2R8zLY>

Уг аргачлалын гол онцлог нь шалгарсан туршлагыг нэвтрүүлэх зорилгоор “төслийн баг” бүрдүүлэн ажиллуулж, туршлага судлах бүс нутаг болон орон нутагт очиж, тухайн туршлагыг нэвтрүүлэх суурь нөхцөл буюу SWOT шинжилгээ хийхийн зэрэгцээ урьдчилан бэлтгэсэн асуулга маягтад үндэслэн үнэлэлт дүгнэлт өгнө. Улмаар сайн туршлагыг нэвтрүүлэх орон нутгийн төлөөлөгчид, мэргэжилтнүүдээс бүрдсэн багт практик сургалт зохион байгуулна. Дараагийн шатанд бүх талууд хамтран сайн туршлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийн үр дүнг хэмжих аргачлалаа тогтох тус тус үе шатнаас бүрддэг. Уг аргыг тодорхой санхүүжилтийн эх үүсвэртэй, экспертийн түвшний мэдлэг чадвартай мэргэжилтнүүдийн оролцоотой, ИТХ-ын сайн туршлагыг нэвтрүүлэх өндөр хэрэгцээ шаардлагад тулгуурлан орон нутгийн шилдэг туршлагыг нэвтрүүлэх зорилгоор ашиглах боломжтой. Монгол Улсын хувьд ИТХ-ын үйл ажиллагаанд сайн туршлагыг нэвтрүүлэхийн тулд донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлбэл үр дүнтэй гэж үзэж байна.

Сайн туршлагыг танилцуулах, эзэмшүүлэх орчин үеийн нэг чухал хэлбэр бол “Харилцан суралцах арга” (Horizontal Learning Program) юм: Харилцан суралцах арга гэдэг нь орон нутгийн онцлогтой мэдлэгийг олж нээх, хамтран суралцах, сайн туршлагыг хямд зардлаар олж эзэмших үйл явц юм.

Харилцан суралцах арга нь чадавхыг нэмэгдүүлэх шинэ арга замыг хайсны үр дүнд Бангладешид анх боловсруулагдсан. Уг арга нь дараах зорилтыг хангадаг.

- Чадавхыг нэмэгдүүлэх. Орон нутаг, хамт олныг өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан өөрийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэх чадавхаа нэмэгдүүлэх боломжийг энэ арга олгоно.
- Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх. Хүн өөрийн туршлагыг бусдад зааж сургаснаар туршлагаа улам чамбайруулж, зарим доголдлыг засаж чадна. Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлснээр чадавхаа бололцооны зардлаар илүү их үр дүнтэйгээр нэмэгдүүлж чадна. Үүнээс үүдэн сайн туршлага хэзээ хэрхэн түгээн дэлгэрүүлэх вэ гэсэн асуулт гарах бөгөөд энэ нь зөвхөн хүмүүсийн хооронд амьд харилцаа үүссэн тохиолдолд л хэн нэгний туршлага нөгөө нэгэнд очих боломжтой болно.
- Хамтрагчдын амьд талбарыг бүтээх. Хамтрагчдын амьд талбар бол амьд харилцаа, итгэлцэл дээр бий болно.

Харилцан суралцах арга зүйг хэрэгжүүлэхэд дараах дөрвөн зарчмыг баримтлах шаардлагатай. Үүнд:

1. Холбогдох /Connection/
2. Талархах /Appreciation/
3. “Хөрсөндөө буулгах” буюу Нутагшуулах /Adaptation/



4. Түгээн дэлгэрүүлэх /Replication/

Хүснэгт 1. Харилцан суралцах арга зүйн 6 үе шат

№	Үндсэн ажил	Хийгдэх ажиллавар
1	Сайн туршлагаа (шалгуур үзүүлэлтийн хамтаар) тодорхойлох	Энд тухайн туршлага яагаад сайн байгаа, үүний үр дүнг ямар шалгуур үзүүлэлтээр хамжих, ямар асуудлыг энэ сайн туршлага шийдэж чадсан, гол оролцогчид нь хэн байсан тэд ямар үүрэг, хариуцлагатай оролцсон зэргийг судлаг үзэх шаардлагатай. Энд хавсралтад байгаа сайн туршлагын баримтыг хүснэгтийг ашиглан түүнийг тодорхойлж болно.
2	Сайн туршлага хуваалцах	Сайн туршлагыг бүтээсэн байгууллагууд нь очиж үзэх суралцахыг хүссэн бусад газрын хэрэгжүүлсэн сайн туршлагаа танилцуулах, нөхцөл байдал/хүрсэн амжилтыг талархан хүлээн авах ажил зохион байгуулах.
3	Сайн туршлагаас суралцах буюу юуг нутагшуулах, шийдэх,	Байгууллага сонгосон сайн туршлагаа иргэдтэйгээ хамтран хэлэлцэн эрэмбэлэн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төсөвлөх. Энд сайн туршлагаас хамгийн түрүүнд юу ямар үр дүн үзүүлэхийг сайн тодорхойлох шаардлагатай.
4	Ач тус хүртэгчидтэйгээ хамтран нутагшуулах төлөвлөгөө хийх	Нэгэнт ямар тэргүүн туршлагыг нутагшуулах шийдвэр гарсны дараа тухайн туршлагыг нутагшуулах төлөвлөгөөг сайн туршлага бүтээгч болон хүлээн авагчид, тухайн сайн туршлагыг үр шимийг хүртэгчид хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө хийнэ. Энд хамгийн түрүүнд хийх ажлаас хамгийн сүүлд хийх зүйлийг багтаасан төлөвлөгөө юм.
5	Сайн туршлагыг нутагшуулах	Энэ нь төлөвлөсөн ажлаа хийнэ гэсэн энгийн ойлголт боловч, сайн туршлагыг өөрийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх явцад хүлээн авагч талд ойлгомжгүй асуудал цөөнгүй удаа тохиолдох бөгөөд заримдаа сайн туршлага бүтээгч ч мэдэхгүй нөхцөл байдал бий болно.
6	Сайн туршлагад тулгуурлан бодлогын нөлөөллийг бий болгох	Нэгэнт сайн туршлагыг нутагшуулахад өөрийн болгож чадсаны дараагийн алхам бол тухайн туршлагыг илүү өргөн хүрээнд бодлогын хэрэгжихгүй байгаа асуудлыг шийдвэрлэх байдал руу хандуулан сайн туршлага хэрэгжүүлсэн багуудтай хамтран бодлогод өөрчлөлт оруулах алхмыг хийх нь тухайн салбарт дахин тэр алдаа давтагдахгүй байх боломжийг бий болгоно.

ИТХ-ын чадавхыг бэхжүүлэх, сайн туршлагыг нэвтрүүлэхэд харилцан суралцах аргыг ашиглах бүрэн боломжтой. Уг аргыг ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалт, уулзалт хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлснээр ИТХ-ын сайн туршлагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх чухал арга хэлбэр болох юм. Ялангуяа орчин үед ИТХ зөвхөн орон нутгийн иргэдийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх төдийгөөр үйл ажиллагаагаа хязгаарлах нь зохисгүй болсон. Ногоон хөгжил, жендер, хүний эрх, эмэгтэйчүүд, залуучууд, нийгмийн эмзэг бүлэг зэрэг нийгмийн бүлгүүдийн ижил тэгш оролцоог хангах зэрэг хүн төрөлхтний орчин цагийн нийтлэг асуудалд анхаарлаа хандуулж, аливаа шийдвэр, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа харгалзах шаардлага тулгарч байна Энэ нөхцөлд харилцан суралцах аргазүйгээр эдгээр орчин үеийн асуудлаарх ИТХ-ын сайн туршлагыг нэвтрүүлэх, сурталчлахад уг аргыг ашиглах нь зохистой гэж үзэж байна.

Европын холбоо, “Европын бүс нутгийн хөгжлийн сан”-гийн хүрээнд 2017 онд хэрэгжүүлсэн “URBACT” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн сайн туршлагыг



нэвтрүүлэх туршилт: Хоёр үе шат бүхий 2-3 сарын туршид хэрэгжүүлсэн уг төслийн хүрээнд хотууд өөрсдийн тулгамдсан асуудал болон харилцан туршлагаа солилцож, орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн түвшинд бий болгосон үр дүнгээ хуваалцах замаар сайн туршлагаа солилцож, түгээн дэлгэрүүлсэн байна. Тус төсөл хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь энгийн “copy and paste” төдий бус “peer-to-peer” буюу харилцан дэмжсэн зарчимд суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорилгоо болгосон. Энэхүү хөтөлбөрийн онцлог нь хөтөлбөрт оролцож буй хотууд сайн туршлагыг нэвтрүүлэхийн тулд харилцан айлчлах, газар дээр нь очиж сайн туршлагын хэрэгжилттэй танилцах, нутаг орны онцлогтой уялдуулах боломж нөхцөлийг судлах бололцоог олгосон байна.

ИТХ-ын сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэхийн тулд уг аргачлалын дагуу ИТХ-ын төлөөлөгчид харилцан айлчлах, орон нутгийн ИТХ-ын үйл ажиллагаа, сайн туршлагатай танилцах, хэрэгжүүлэх арга замаа хамтран боловсруулахад уг аргазүйг ашиглаж болно.

Орон нутгийн онцлог, нөхцөл байдлаа харгалзан бусад ИТХ-ын сайн туршлагыг бенчмаркинг аргад тулгуурлан нэвтрүүлэх: ИТХ нь бусад хурлуудын сайн туршлагыг авч орон нутагтаа нутагшуулахад бенчмаркинг аргыг хэрэглэх бүрэн боломжтой юм. Бенчмаркинг нь мэдээлэл олох, тэдгээрийг үнэлэх, бусдаас суралцах, илүү сайжруулан сэтгэх, илүү өндөр түвшинд ажиллах зэрэг олон цогц үйл ажиллагаанаас бүрддэг. Өөрөөр хэлбэл бенчмаркингийг хэрэглэхдээ бусдын сайн туршлагыг тэр чигээр нь авч хуулбарлах бус харин тухайн сайн туршлагын гол санаан дээр дөрөөлөн орон нутгийнхаа онцлог, нөхцөл байдалд тохируулан илүү онцгой, шинэлэг аргыг нэвтрүүлэх нь чухал. Үүний тулд тухайн асуудлын хүрээнд нэгд, ИТХ, орон нутгийн давуу болон сул талыг тодорхойлох хоёрт, ИТХ, орон нутгаа бусадтай буюу тухайн сайн туршлагыг нэвтрүүлсэн ИТХ-тай харьцуулан үзэж, түвшинээ тодорхойлох гуравт, ИТХ нь үйл ажиллагааг сайжруулах болон өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах алхмуудыг гүйцэтгэх хэрэгтэй. Бенчмаркингийг хэрэгжүүлэх үндсэн 2 хүрээ бий.

Нэгд, Дотоод дахь бенчмаркинг: Байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд гадаад орчноос нөлөөлөх хүчин зүйлүүд байх боловч ихэнх тохиолдолд дотоод үйл ажиллагааны алдаа, сул талаас үүдэлтэй байх нь элбэг. Үүнийг бас шийдвэрлэх боломжийг дотоодоос олж авч болно. Энэ нь байгууллага нэгж, хэлтсүүдийнхээ үйл ажиллагаа, ажлын арга барилыг харьцуулах замаар үйл ажиллагааг сайжруулах арга юм. Харин бидний авч үзэж буй сэдвийн хүрээнд хоёр дахь бенчмаркингийг ашиглах нь оновчтой юм.

Хоёрт, Гадаад бенчмаркинг: Энэ нь өөрийн байгууллагыг бусад ИТХ-ын сайн туршлагатай харьцуулах юм.

Бенчмаркинг хийхдээ тодорхой технологи, дэс дараалалтай алхмуудыг хийх хэрэгтэй.

Бенчмаркинг хийх хэд хэдэн үе шат байна.

- Өөрийн үйл ажиллагаанд нарийвчилсан шинжилгээ хийх
- Бусад ИТХ-ын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх
- Өөрийн ИТХ-ыг бусад ИТХ-тай харьцуулж үнэлгээ өгөх
- Алдагдлыг багасгахад зайлшгүй хийгдэх ёстой шинэчлэлүүдийг тодорхойлох
- Шинэ ба боловсронгуй болсон сайн туршлагыг хэрэгжүүлэх

Дэс дараалал бүхий алхмууд ба аргачлал :




- Бенчмаркинг хийх ямар үйл ажиллагаа, асуудал, үйлчилгээ, процесс байгааг тодорхойлох
- Бенчмаркинг хийх ижил төстэй сайн туршлагыг сонгох
- Гүйцэтгэл, туршлагатай холбоотой мэдээлэл цуглуулах
- Мэдээлэлд шинжилгээ хийж, сайжруулалтын боломжуудыг тогтоох
- Сайн туршлагауудыг хөрвүүлэн хэрэгжүүлэх, боломжит зорилгыг тодорхойлох, байгууллага бүхэлдээ хүлээн зөвшөөрч, авч хэрэгжүүлэх

Бэнчмаркингийн давуу тал: судалгааны бодит дүн шинжилгээнд үндэслэх тул эдийн засгийн төлөвлөлтийг хийхэд илүү сайн, хэрэглэгчдийнхээ хүсэл шаардлага хэрэгцээг зөв олж мэдэж чаддаг. Мөн тухайн судалгааг сайжруулан өөрийнхөө байгууллагын стратегийг боловсруулахаас гадна бусад ИТХ-ын сайн туршлагын талаар бүрэн мэдээлэлтэй болж чадах юм.

Бэнчмаркетингийн сул тал: судалгааны явцад их хэмжээний цаг хугацаа болон хөрөнгө мөнгө зарцуулдаг.

Сайн туршлагыг нэвтрүүлэх 5 асуултын арга: Энэ 5 асуултын арга нь нөхцөл байдлын талаар хамгийн чухал ойлголтуудыг богино хугацаанд таних арга юм. Аргачлалын гол утга санаа нь учир шалтгааныг тодорхойлох гэж ойлгож болно. Тухайн асуудал, үйл ажиллагааны өмнө бий болсон сайн туршлага болон одоо тулгамдаж буй асуудал, үйл ажиллагааг сайжруулахад үүсэх асуудлыг хэлэлцэхэд хэрэглэнэ. 5 асуулт нь дараах асуудлуудыг илрүүлэхэд чиглэгдэнэ.

Зураг 5. Сайн туршлагыг нэвтрүүлэх 5 асуулт



Асуултуудын бүрэлдэхүүн хэсгийн гол зарчим нь асуулт бүр бодит байдалтай нийцэж байх ёстой.

Асуудлын шинжилгээний аргыг ашиглан сайн туршлагыг нэвтрүүлэх: Асуудал гэдэг нь одоогийн нөхцөл байдал, байлгахыг хүсэж буй нөхцөл байдал хоёрын хоорондох зөрүү юм. Асуудлыг нарийвчлан тодорхойлох нь үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэс болно. Тиймээс асуудлын зөвхөн нэг шинж чанарыг нь харж шийдэх нь учир дутагдалтай, бүхэлд нь буюу бүх талаас нь авч үзэж байж шийдэх нь чухал. Нөхцөл байдлыг тодотгох, гол асуудлыг нягтлан гаргах, тойрсон бусад асуудлыг гаргаж түүний шалтгаан, үр дагаврын хамаарлыг харах боломжтой болно. Асуудлын учир шалтгаан, үр

нөлөө, мөн чанарыг “асуудлын мод”-ны аргаар тодорхойлох нь ойлгомжтой, томъёолол хийхэд дөхөм, өргөн оролцоотой болдог.

Хүснэгт 2. Асуудлын учир шалтгаан, үр нөлөө

Гол асуудал	Хэрэгжилтэд асуудал үүсгэж буй шалтгаан	Шалтгаанд нөлөөлөх гол хүчин зүйлс	Гарч буй сөрөг нөлөө


Дараагийн алхам бол ижил төстэй асуудлыг шийдвэрлэсэн, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн сайн туршлагыг асуудлын учир шалтгаан, үр нөлөөг харгалзан харьцуулан үзэж өөрийн байгууллага, орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тохируулан илүү онцгой, шинэлэг аргыг нэвтрүүлэх юм.

Хүснэгт 3. Сайн туршлагатай харьцуулах

Чиглүүлэх асуулт	Шийдвэрлэх асуудал	Ижил төстэй асуудал /сайн туршлага /	Харьцуулалт /шинж чанар/
Хэний ашиг сонирхол зөрчигдөж байна вэ ?			
Хэн ямар үүрэгтэй оролцох вэ ?			
Хаана хэрэгжүүлэх вэ ?			
Ямар арга хэрэглэх вэ ?			
Гарч болох ямар эрсдэл байх вэ ?			
Хэрхэн шийдвэрлэх вэ ?			
Хүрэх үр дүнгээ хэрхэн хэмжих вэ ?			

Тэнцвэржүүлсэн үнэлгээний карт (Balanced Scorecard)-ыг ашиглан сайн туршлагыг ИТХ-д нэвтрүүлэх: ИТХ-ын сайн туршлагыг авч хэрэгжүүлэхдээ шууд хуулбарлах нь төдийлөн үр ашигтай биш юм. Учир нь өөр орчин, нөхцөл байдал, хүн ам, нийгэм, эдийн засгийн ялгаатай орчинд туршлагыг бодит ажил болгон хэрэгжүүлэхэд өөрийн онцлог, нөхцөл байдалд тохируулан нутагшуулахад Тэнцвэржүүлсэн үнэлгээний карт (Balanced Scorecard)-ийг ашиглах боломжтой юм. Өөрөөр хэлбэл хэрэгжилтийг төлөвлөхөд тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг ашиглах нь ихээхэн үр дүнтэй байдаг. Энэ нь байгууллага урт хугацаанд оршин тогтнохын тулд холын зорилго дэвшүүлж, түүндээ хүрэх үйл ажиллагааг өдөр тутамдаа хэрэгжүүлж чадах зохион байгуулалтын хэлбэрийг бий болгох арга юм. Түүнчлэн, үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийг “тэнцвэржүүлсэн үнэлгээний карт” дээр нэгтгэж хувийн жинг үнэлж болно. Энэ бол байгууллагын гол зорилгуудын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг, “иргэд ба хэрэглэгчдийн үр дүн”, “үйл явцын сайжруулалтын үр дүн”, “байгууллагын суралцахуй ба хөгжлийн үр дүн”, “санхүүгийн үр дүн” гэх зэрэг бүлгүүдэд хувааж тогтоох арга юм

Зураг 6. Тэнцвэржүүлсэн үнэлгээний арга



1. **Хэрэглэгчийн хэтийн төлөв:** Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг бий болгоход чиглэсэн байх, түүнийг хэмжих. Хэтийн төлөвтөө хүрэхийн тулд хэрэглэгчдэдээ өөрийгөө хэрхэн харуулах
2. **Дотоод үйл ажиллагаа:** Хэрэглэгчийг сэтгэл ханамжтай байлгахын тулд ямар үйл ажиллагаагаар ялгарах (хамтын ажиллагаа, стратегийн удирдлага, төслийн удирдлага, чанарын удирдлага, мэдээлэл харилцаа холбооны шинэчлэл гэх мэт)
3. **Санхүүгийн хэтийн төлөв:** Үргэлж хангалттай санхүүгийн мэдээлэлтэй байх. Санхүүгийн зөв мэдээллийг цаг тухай бүрд хүргэж байх. Санхүүгээ амжилттай байлгахын тулд хэрэглэх (төсөв хөрөнгийн үр ашигтай зарцуулж зорилгод хүрсэн байх)
4. **Суралцах болон хөгжих хэтийн төлөв:** Хэтийн төлөвтөө хүрэхийн тулд хэрхэн өөрчлөгдөх болон сайжрах чадвараа нэмэгдүүлэх, хувь хүн болон байгууллагын хөгжих чадвартай холбоотой. Менежер сургалт зохион байгуулахад юунд илүү анхаарахад нь чиглүүлж өгдөг (гүйцэтгэлийг сайжруулах, байгууллагын соёл, мэдлэгийн менежмент гэх мэт).

Тухайн үйл ажиллагааг ийнхүү дөрвөн бүлгүүдэд хуваан авч үзсэнээр хариуцагч, удирдагч нар үйл ажиллагааны үйл явцыг бүхэлд нь том зургаар харах болон эн тэнцүү хэрэгжүүлэх удирдамж болж өгдөг. Өөрөөр хэлбэл, нэг ижил байдлаар хуваарилсан нөхцөлд байгууллагын нэгж бүр нэг адил чиглэл, зорилгыг байгууллагын хамтын нийтлэг зорилго байдлаар авч хэрэгжүүлнэ. Хувь нэмэр оруулах хуваарилалтын үед, байгууллагын нэгжүүд хамтын нийтлэг зорилгод өөрсдийн оруулах хувь нэмрийг тодорхойлдог. Шинэ хуваарилалтын үед байгууллагын нэгжүүд нийт байгууллагын хүрээнээс гадна үйл ажиллагааны шаардлагаас хамаарсан өөрсдийн онцлогт тохирсон зорилгыг тодорхойлох боломжтой байдаг.

Тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг ашиглах аргачлал :

- Зорилго эсвэл үйл ажиллагааны зорилгыг тодорхойлох
- Зорилготой холбогдох хэрэгжүүлэлтийн нэгжүүдийг тодорхой болгох (Хэрэглэгч, байгууллагын дотоод үйл ажиллагаа, суралцах, санхүү)
- Зорилготой уялдсан төлөвлөгөө гаргах
- Зохистой хэмжигдэхүүн, стандартуудыг тогтоож, богино хугацааны зорилтууд тавих

- Оновчтой төсөв, хяналтын тогтолцоо, харилцаа холбоо болон урамшууллын систем боловсруулах
- Гүйцэтгэлийн мэдээлэл цуглуулж анализ хийх, төлөвлөгөөтэй харьцуулах
- Гүйцэтгэлийн зөрүүг багасгах арга хэмжээ авах

Гүйцэтгэх алхмууд:

Зорилгыг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэлийн зорилго, хүрэх үр дүн, үйл ажиллагааг ямар үйл явцын дагуу тодорхойлох вэ? Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд тодорхойлно.

1. Байгууллагын үндсэн чиг үүрэг:

2. Зорилго:

3. Гүйцэтгэлийн зорилго (Дээр дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд түүнийг 1-2 гүйцэтгэлийн зорилго болгон томъёолох):

Гүйцэтгэлийн зорилго 1.

Гүйцэтгэлийн зорилго 2.

4. Гүйцэтгэлийн зорилгод хүрэхэд ямар тулгамдсан асуудал байгааг тодорхойлох (өмнөх буюу 3-р зүйлд тодорхойлсон гүйцэтгэлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд ямар тулгамдсан асуудал байгааг дараах 4 хэтийн төлөв тус бүрийн хүрээнд тодорхойлох):

1. Хэрэглэгч /Customer/

2. Байгууллагын дотоод үйл ажиллагаа /Internal process/

3. Суралцах/Learning

4. Санхүү /Finance/

5. Дээрх асуудлуудыг орон нутаг, иргэдэд үзүүлэх хувь нэмрээр нь эрэмбэлэх

1.

2.

3.

4.

6. Эрэмбэлсэн асуудал тус бүрийн хувьд хүрэх түвшнийг гарц ба үр дагавар гэсэн хоёр хэмжигдэхүүний хүрээнд тодорхойлох (хүрэх үр дүнг SMART хэлбэрээр буюу цаг хугацаатай, тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц байдлаар тодорхойлох)

1. Хэрэглэгч /Customer/

- Гарц буюу хийх ажил /output/:

- Үр дагавар буюу хүрэх үр дүн /Outcome/:

2. Байгууллагын дотоод үйл ажиллагаа /Internal process/

- Гарц буюу хийх ажил /output/:

- Үр дагавар буюу хүрэх үр дүн /Outcome/:

3. Суралцах/Learning/

- Гарц буюу хийх ажил /output/:

- Үр дагавар буюу хүрэх үр дүн /Outcome/:

4. Санхүү /Finance/

- Гарц буюу хийх ажил /output/:
- Үр дагавар буюу хүрэх үр дүн /Outcome/:

7. Дөрвөн хэтийн төлөвийн хүрээнд тодорхойлсон гарц тус бүрийн хувьд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойлох (гарц буюу үр дүнд хүрэхэд ямар үйл ажиллагааг явуулах хэрэгтэй вэ? гэдгээ тодорхойлох):

1. Хэрэглэгч /Customer/:
2. Байгууллагын домоод үйл ажиллагаа /Internal process/ :
3. Суралцах/Learning/:
4. Санхүү /Finance/:

8. Дээр төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа бодит хэрэгжилтийн үр дүнг 6-д тодорхойлсон гарц буюу хүрэх үр дүнтэй харьцуулан үзэж, гүйцэтгэлийн зөрүү гарвал багасгах арга хэмжээ авна.

Эцэст нь хэлэхэд, ИТХ-ын сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэхийн тулд уг аргачлалын дагуу төлөвлөх болон ИТХ-ын төлөөлөгчид харилцан айлчлах, орон нутгийн ИТХ-ын үйл ажиллагаа, сайн туршлагатай танилцах, хэрэгжүүлэх арга замаа хамтран боловсруулахад дээрх аргагүйг ашиглаж болно.

2. ИТХ-ын сайн туршлагыг сурталчлан түгээх санал зөвлөмж

ИТХ-ын сайн туршлагын мэдээлэл, агуулгыг сурталчлан түгээх арга хэмжээг дараах байдлаар авч үзэж болно.

- **Хэвлэмэл хэлбэрээр сурталчлах:** Нийслэлийн дүүргийн ИТХ болон аймаг, сумдын ИТХ-ын сайн туршлагыг эмхэтгэсэн гарын авлагыг хэвлэн 21 аймаг, 330 суманд хүргүүлэх. Зөвхөн ИТХ-ын ажлын албанд төдийгүй ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд боломжтой бол нийт ИТХ-ын төлөөлөгчдөд хүрэлцэхүйц тоо хэмжээгээр хэвлэж, гар дээр нь хүргэх. Нийт ИТХ-ийн төлөөлөгчдөд файлаар буюу PDF хэлбэрт оруулан цахим шуудангаар илгээж болно. Энэхүү гарын авлагад багтсан аймаг, сумын ИТХ-ын сайн туршлага нь тухайн ИТХ болон нэр дэвшихээр өрсөлдөж буй нам хүчин, төлөөлөгчдийн хувьд орон нутгийн сонгуульд өөрсдийн бодлого, үйл ажиллагааг тайлагнах, танилцуулах, өөрсдийгөө сурталчлах нэг том боломж юм. Иймд тухайн ИТХ-ийн төлөөлөгч гарын авлагыг нэмж авах, иргэдэд тараахыг хүсвэл хэвлэж өгөх болон хэвлэж авахыг зөвшөөрч PDF хэлбэрээр илгээж болно. Мөн орон нутгийн сонгууль дууссаны дараагаар буюу 2020 оны 10-р сараас хойш шинээр бүрэлдсэн аймаг, сумын ИТХ-д сайн туршлагын гарын авлагыг дахин тараах нь шинэ төлөөлөгчдийн хувьд чухал хэрэглэгдэхүүн болох магадлалтай.
- **Цахим хэлбэрээр сурталчлан таниулах:** ИТХ-ын нэгдсэн цахим хуудас буюу khural.mn сайт дээр сайн туршлагын эмхэтгэлийг цахим хэлбэрээр байршуулах. Мөн сайн туршлага бүрийг 7 хоногийн давтамжтайгаар байршуулж, сайтын хандалтыг нэмэгдүүлэх. Тус сайт дахь “сайн туршлага” булан 2016 оноос хойш мэдээ тавигдаагүй байна. Орон нутгийн мэдээллийн сайтуудад сайн туршлагыг сурталчлах. Сайн туршлагын эмхэтгэлд багтсан аймаг, сумын ИТХ-ын сайн туршлагыг тухай аймгийн мэдээллийн цахим талбар буюу аймгийн ЗДТГ-ын эрхэлдэг сайтад байршуулах. Нийгмийн сүлжээ буюу орчинд аймаг, сумын facebook групп дээр сайн туршлагыг энгийн сонирхолтой хэлбэр, бичлэгийн хэв маягт оруулж нийтлэх, идэвхжүүлэх боломжтой гэж бодож байна.
- **Сургалт судалгааны хэлбэрээр сурталчлах:** ИТХ-ын ажлын алба, төлөөлөгчдөд зориулсан сургалт, уулзалт хэлэлцүүлгийн үеэр сайн туршлагын гарын авлагыг

тараах, сургалтын явцад сайн туршлагын эмхэтгэлийг ашиглахыг багш, суралцагчдад санал зөвлөмж болгох. Ялангуяа Удирдлагын академитай хамтран зохион байгуулдаг ИТХ-ыг чадавхжуулах сургалтад тус гарын авлагыг ашиглах, сургалтын кейс болгох бүрэн боломжтой гэж үзэж байна. Судалгаа, гарын авлага хэлбэрээр ашиглуулах, эргэлтэд оруулах зорилгоор аймаг, орон нутгийн номын сан, их дээд сургуулийн номын сан, судалгааны хүрээлэнд өгөх, номын сангуудын сайт дээр үнэ төлбөргүй унших бололцоог хангах.

- **Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах:** Төслийн хүрээнд ИТХ-ын сайн туршлагын гарын авлага хэвлэгдсэн болон тус гарын авлагын ач холбогдол, үр нөлөөг танилцуулсан мэдээ, мэдээллийг телевиз, радио болон үндэсний хэмжээний портал сайтуудаар дамжуулан олон нийтэд цацах. Энэ нь иргэд, сонгогчдод зориулсан мэдээлэл гэхээсээ илүү ИТХ-ын төлөөлөгчид уншиж, танилцах чухал сэдэл болох гэдэг талаасаа ач холбогдолтой сурталчилгааны арга хэлбэр юм. Мөн Монголын үндэсний радио, телевизтэй тохиролцсоны үндсэн дээр зарим сайн туршлагыг газар дээр нь очиж танилцуулсан товч мэдээ бэлтгүүлэн мэдээллийн хэрэгслээр цацах боломжтой гэж тооцож байна. Сайн туршлагаа хуваалцах, сурталчлахад орон нутгийг богино долгионы радио, орон нутгийн сонин хэвлэл, телевизийн нэвтрүүлгийг ашиглах, тухайн сайн туршлагыг санаачилж хэрэгжүүлсэн ИТХ-ын төлөөлөгчид, нам хүчнийг оролцуулах, ярилцлага, нийтлэл гаргахад анхаарах.
- **Сайн туршлага хуваалцах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах:** ИТХ-ын сайн туршлагын эмхэтгэлд багтсан ИТХ-ын төлөөллийг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлэг болон сургалт зохион байгуулах. Сайн туршлагыг санаачилж, хэрэгжүүлсэн тухайгаа бусад төлөөлөгчдөдөө биечлэн танилцуулах, сурталчлах, туршлага солилцох өргөн боломжийг энэхүү арга хэмжээ олгоно. Хэлэлцүүлгийг дараах байдлаар бүлэглэн зохион байгуулж болохын зэрэгцээ холимог хэлбэрээр явуулах боломжтой. Үүнд:
 - Иргэдийн оролцоо
 - Байгаль орчин
 - Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо
 - ИТХ-ын хяналт
 - ИТХ-ын чадавхыг бэхжүүлэх

Энэхүү арга хэмжээ нь ИТХ-ын төлөөлөгчдийн хувьд цаашид сайн туршлагаа хуваалцах, санаачилгатай ажиллахад чухал түлхэц болохуйц үйл ажиллагаа байх юм. Мөн уг туршлага солилцох аргыг харилцан суралцах аргазүйтэй хослуулсан байдлаар явуулах боломжтой.

- **Сайн туршлагыг нэвтрүүлэх явдлыг дэмжих:** Сайн туршлагын гарын авлагыг ИТХ-ын төлөөлөгчдөд хүргүүлсний дараа сайн туршлагыг нэвтрүүлэх сонирхол эрмэлзэлтэй ИТХ-ын дэмжих зорилгоор сайн туршлага нэвтрүүлэхийг дэмжих төсөл шалгаруулах уралдааныг аймаг сумын ИТХ-ын дунд зохион байгуулах боломжтой. Хугацааны хувьд үүнийг 2020 оны орон нутгийн сонгууль явагдсаны дараа зохион байгуулбал оновчтой хэмээн тооцож байна.
- **Үзүүлэх сургууль зохиох:** Сайн туршлагыг нэвтрүүлэгчийн туршлагыг бусдад бодитоор үзүүлэх, сургууль зохиох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, тухай сайн туршлагыг санаачлагч болон хариуцан хэрэгжүүлэгчидтэй гэрээ хийсний үндсэн

дээр бусад ИТХ-ын онцлогт тохируулан хэрэгжүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлж болно.

- **Тодорхой байгууллагыг туршлага нэвтрүүлэх бааз, лаборатори болгох:** Тодорхой сайн туршлага болон хэрэгжүүлэх ИТХ-ыг сонгон, олон улсын байгууллагын санхүүжилтээр олон улсын эксперт, зөвлөхүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, сайн туршлагыг хөгжүүлэх, илүү дэвшилтэт шатанд хүргэх зорилго бүхий бааз, лабораторийг бий болгож болно.
- **Туршлага нэвтрүүлсэн байгууллагад урамшуулал, сертификат олгох:** Сайн туршлагыг нэвтрүүлж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагыг өөрийн санаачилгаар урамшуулах нэр хүнд бүхий байгууллага, олон улсын байгууллагын нэрэмжит урамшууллыг бий болгож, алдаршуулах сертификат олгон, түүнийг уламжлал болгон төлөвшүүлж болно.

Дээрх сурталчлан таниулах арга хэлбэрүүдийг дангаар нь болон сорчлох, бүгдийг нь хослуулах зэрэг төрөл бүрийн байдлаар зохион байгуулж болно. Аль болох олон арга хэмжээг хослуулах нь сайн туршлагыг ИТХ-ын ажлын алба, төлөөлөгчдөд сурталчлах, үр нөлөөтэй ашиглах, нэвтрүүлэх бололцоог нэмэгдүүлэх юм.